

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ, СУМДЫН
2019 ОНЫ 12 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2020.01.02

Сүхбаатар сум

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчдийн үйл ажиллагааны талаар

Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын **Төлөөлөгчид** энэ сард 1 удаа хуралдаж 3 асуудал хэлэлцэн 2 тогтоол баталлаа. Үүнд:

1.Сэлэнгэ аймгийн 2020 оны төсөв батлах тухай асуудлыг хэлэлцээд аймгийн 2020 оны төсвийн орлогыг 18.249.000.0 мянган төгрөгөөр, зарлагыг 9.934.038.5 мянган төгрөгөөр баталж, Төсвийн тухай хуулийн 42.2-т заасны дагуу төсөвтөө зохицуулалт хийж ажиллахыг аймгийн Засаг даргад, төсвийн бүрдүүлэлт зарцуулалтад байнгын хяналт тавьж, төсвийн хуримтлагдсан өр, авлагыг бууруулж, шинээр үүсгэхгүй ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт үүрэг болголоо.

2.Байгалийн ургамал ашигласны төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай асуудлыг хэлэлцээд аймгийн нутаг дэвсгэрт байгалийн ургамал түүж бэлтгэх төлбөрийн хэмжээг ховор ургамлын 30 нэр төрөл, элбэг ургамлын 31 нэр төрлөөр шинэчлэн тогтоолоо.

Аймгийн ИТХ-ын **Тэргүүлэгчид** энэ сард 2 удаа хуралдаж 20 гаруй асуудал хэлэлцэн 28 тогтоол баталлаа. Үүнд:

1.Сэлэнгэ нутагт атар газар эзэмшин, газар тариаланг шинжлэх ухааны үндэслэлтэй хөгжүүлсэн 60 жилийн түүхийг бүтээлцэхэд сэтгэл, зүтгэл, мэдлэг чадвар, удирдахуйн арга ухаанаа зориулсан Шаравын Гунгаадорж, Бадарчийн Пүрэвжав, Лувсангийн Алтангэрэл, Жалсрайн Баярмагнай, Содын Бүрэнбат, Дагвын Бадарч, Хандмаагийн Даваахүү нарын 7 иргэнийг Сэлэнгэ аймгийн “Хүндэт иргэн”-ээр өргөмжлөв.

2.Газар зүйн хүрээлэнгийн судлаачдын Сэлэнгэ аймгийн хамгийн нам цэгийг тодорхойлсон гүйцэтгэлийн ажлыг үндэслэн Түшиг сумын нутаг, улсын хилийн зурваст орших Эрээн тохой гэдэг газрын 576053,15”, 5582501,42” солбицол нь далайн түвшнээс дээш 592.6 метр оршин байгаа нь тогтоогдсон тул Сэлэнгэ аймгийн хамгийн нам дор цэгээр тогтоов.

3.Аймгийн нутаг дэвсгэрээс 2019 онд ойгоос нэмэлтээр мод бэлтгэх аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 77 дугаар тогтоолын хавсралтад заасан Цагааннуур сумаас үйлдвэрлэлийн огтлолоор 1000 м3 шинэс мод бэлтгэх гэж заасныг Түшиг сумаас үйлдвэрлэлийн огтлолоор 1000 м3 бэлтгэхээр өөрчлөн тогтоолоо.

4.Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 132 дугаар тогтоолоор баталсан “Зарим бүтээлийг бүх нийтээр судлах, сурах тухай” тогтоолд “Ж.Лхагва, Н.Сүхдоржийн үг, Ц.Чинзоригийн ая “Сэлүүн дэнжийн яргуй”” гэж, мөн тогтоолд “Г.Даваацэрэнгийн үг, Г.Дарамзагдын ая “Өргөн Сэлэнгэ” гэж тус тус залруулан тогтоов.

5.Монгол улсын Шинжлэх ухааны Гавьяат зүтгэлтэн Шархүүгийн Ялалтын шинжлэх ухааны салбарт оруулсан хувь нэмэр, электрон техникийн чиглэлээр технологи боловсруулан шинэ бүтээл гаргаж олон улсад нэвтрүүлсэн гавьяа зүтгэлийг нь үнэлэн, хойч үедээ үлгэр дуурайлал болгон мөнхжүүлэх зорилгоор Мандал сумын улсын тэргүүний 1 дүгээр сургуулийг Монгол улсын Шинжлэх ухааны Гавьяат зүтгэлтэн Шархүүгийн Ялалтын нэрэмжит болголоо.

6.Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны “Журам батлах тухай” 118 дугаар тогтоолын үндэслэл хэсэгт “Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор баталсан журмыг” гэснийг уг журам хүчингүй болсонтой холбогдуулан хасаж өөрчлөв.

7.Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны “Журам батлах тухай” 42 дугаар тогтоолын үндэслэл хэсэгт “Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор баталсан журмыг” гэснийг “Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 204 дүгээр тогтоолоор баталсан журмыг” гэж өөрчлөн тогтоов.

8.Аймгийн Засаг даргын саналыг үндэслэн зарим сум байгууллагуудын үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрлийг олгов.

9.Эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан зарим хүмүүсийг гавьяат цолоор шагнуулахаар МУ-ын Ерөнхийлөгчид уламжлав. Үүнд: Дугаржавын Нинаг МУ-ын Урлагийн гавьяат зүтгэлтэн цолоор, Дамбын Хишигдоржийг МУ-ын Гавьяат багш цолоор, Намжаагийн Даваанямыг Хөдөө аж ахуйн гавьяат механикжуулагч цолоор, Нацагийн Хишгээг МУ-ын Гавьяат агрономич, Намсрайн Ганболдыг Аж үйлдвэрийн гавьяат ажилтан, Дэлгэр-Очирын Баатаржавыг Аж үйлдвэрийн гавьяат ажилтан, Дамирангийн Валяхүүг Аж үйлдвэрийн гавьяат ажилтан, Галсанжамцын Лувсанямыг Хөдөө аж ахуйн гавьяат механикжуулагч цолоор шагнуулахаар уламжлав.

10.Сэлэнгэ аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр дараах иргэдийг шагналаа. Үүнд: Зэвэгийн Цэнгэлмаа, Гомбын Отгонгэрэл, Тогтохын Цэрмаа, Оролмаагийн Долгормаа, Аюушийн Алдар.

11.Атар газар эзэмшсэний 60 жилийн ойг тохиолдуулан газар тариалан, хүнс, барилгын салбарын Сэлэнгэ аймгийн харьяат зарим иргэдийг одон, медалиар шагнуулахаар Монгол улсын Ерөнхийлөгчид уламжлав. Үүнд: Сүхбаатарын одонгоор 1, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 2, Алтан гадас одонгоор 26, Хөдөлмөрийн хүндэт медалиар 19 хүнийг шагнуулахаар уламжлав.

12.Алтанбулаг сумын уугуул, Монгол улсын Урлагийн гавьяат зүтгэлтэн Монголын анхны мэргэжлийн кино зохиолч, найруулагч Цэвээний Зандраагийн кино урлагийн салбарт оруулсан хувь нэмэр, гавьяа зүтгэлийг нь үнэлэн, хойч үедээ үлгэр дуурайлал болгон мөнхжүүлэх зорилгоор Алтанбулаг сумын Соёлын төвийг Монгол улсын Урлагийн гавьяат зүтгэлтэн Цэвээний Зандраагийн нэрэмжит болголоо.

13.2020 онд үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалттай хэрэглээний мод, түлээ бэлтгэх хуваарийг хэлэлцэн батлав.

14.Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн явц, үр дүнгийн үнэлгээ, Сэлэнгэ аймгийн эдийн засаг нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн үнэлгээг харгалзан аймгийн Засаг даргад мөнгөн урамшуулал олголоо.

2.Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар

Монгол Улсад атар газрыг эзэмшиж, шинжлэх ухааны үндэслэлтэй хөгжүүлсний түүхт 60 жилийн ойн баярын арга хэмжээг 12-р сарын 4-6-ний өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүллээ. Ойн арга хэмжээний хүрээнд аймгийн ИТХ-ын хүндэтгэлийн хурал, баярын хурал, бөхийн барилдаан, хүндэтгэлийн хүлээн авалтыг тус тус зохион байгууллаа. Аймгийн ИТХ-ын хүндэтгэлийн хурлыг 12-р сарын 4-нд зохион байгуулж, аймгийн ИТХ-ын төлөөлөгчдөд Атар газрыг эзэмшсэний 60 жилийн ойн медалийг гардуулж, хүндэт дэвтэрт гарын үсгийг нь мөнхөллөө. Ойд зориулсан үндэсний бөхийн барилдаанд улсын арслан Пүрэвдагва, улсын харцага Бат-Өлзий, Одгэрэл, улсын начин Амарзаяа, Б.Орхонбаяр, Н.Баярбаатар тэргүүтэй улс, аймгийн алдар цолтой 64 бөх уран мэхийг уралдуулан барилдаж, Цагааннуур сумын харъяат улсын начин Б.Орхонбаяр түрүүлж, улсын начин Амарзаяа үзүүрлэлээ.

Баярын үйл ажиллагаанд газар тариалангийн хөгжлийг бодлогын түвшинд дархлаж ажилласан үе үеийн аймгийн удирдлагууд, Атрын 1, 2, 3-р аяныг амжилт дүүрэн бүтээсэн баатар, гавьяатууд, улс аймгийн аваргууд, тариаланчид маань оролцсон бөгөөд Сэлэнгэ нутгаас сонгогдсон УИХ-ын гишүүн Ж.Эрдэнэбат, Н.Оюундарь, Д.Эрдэнэбат нар хүрэлцэн ирж тариаланчиддаа мэндчилгээ

дэвшүүлснээс гадна Сэлэнгэ аймагтай хамтын ажиллагаатай ажилладаг ОХУ-ын Буриад улс, Япон улсын Шизоука муж, Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн хүндэт зочид хурлын индрээс баярын мэндчилгээг хүргэсэн. Сэлэнгэ нутгийн тариаланчид атар газар эзэмшиж эхэлснээс хойших түүхэн хөгжлийн энэ 60 жилийн хугацаанд 8.5 сая тн үр тариа, 1.1 сая тн төмс, 685.0 мянган тн хүнсний ногоо хураан авч, 32 хөдөлмөрийн баатар, 25 гавьяат, 357 улсын аваргыг төрүүлэн гаргасан байна. Энэ үеэр аймгийн хөгжил цэцэглэлтэд хувь нэмрээ оруулж нэр төртэй ажиллаж байсан зарим ахмад настнуудад Ш.Гунгаадорж, н.Пүрэвжав, Л.Алтангэрэл, С.Бүрэнбат, Д.Бадарч, Х.Даваахүү нар атрын 60 жилийн баярын хойморт "Сэлэнгэ аймгийн хүндэт" иргэн хэмээх эрхэм алдрын эзэд боллоо.

"Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдөр"-ийг тохиолдуулан аймгийн Засаг дарга аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны төлөөллийг 12-р сарын 3-ны өдөр хүлээн авч, тэдний санал хүсэлтийг сонсож харилцан ярилцлаа. Уулзалтын үеэр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байрны асуудлыг шийдвэрлэж, аймгаас 2020 оныг "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих жил" болгохоор төлөвлөөд байгаагаар илэрхийлсэн. Үүний дагуу 12-р сарын 19-нд Сэлэнгэ аймгийн удирдлагын багийн санаачилга, хүсэлтийн дагуу УБТЗ-ын хувь нийлүүлсэн нийгэмлэгийн удирдах зөвлөлийн шийдвэрээр аймгийн төв Сүхбаатар сумын 7-р багт байрлах төмөр замын цэцэрлэгийн хуучин байрыг аймгийн мэдэлд албан ёсоор хүлээлгэн өгсөн бөгөөд энэхүү байрыг аймгийн тусгай хэрэгцээт иргэд болон "Ган зам" 7-р багийн төв байрлах төрийн үйлчилгээний цогц байр болгохоор төлөвлөөд байна.

Аймгийн онцгой комисс 12-р сарын 24-ний өдөр хуралдаж өвөлжилтийн нөхцөл байдлын талаарх Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын мэдээлэл, томуу, томуу төст өвчлөл аймгийн хэмжээнд ямар хэмжээнд байгаа талаар ЭМГ-ын дарга, БСУГ-ын даргын мэдээллийн тус тус сонсож, аймгийн хэмжээнд томуу томуу төст өвчний нөхцөл байдал 20 хувьд хүрснийг харгалзан онцгой комиссын гишүүдийн саналаар сургуулийг 12 дугаар сарын 25-ны өдрөөс 28-ны өдрийг дуустал 3 хоног, цэцэрлэгийг 12 дугаар сарын 25-ны өдрөөс 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийг дуустал түр хугацаагаар хааж, нөхцөл байдлын мэдээг холбогдох дээд шатны байгууллагад уламжлахаар шийдвэрлэж, түр хугацаагаар хаасан хугацаанд сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд олон нийтийн арга хэмжээ, секц дугуйлан хичээллүүлэхгүй байхад хяналт тавьж, хэрэгжүүлж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болголоо.

Аймгийн хэмжээнд халаалтын зуухын 15,263 тн буюу нийт 18 хоногийн нүүрсний нөөцтэй хэвийн горимоор үйл ажиллагаа явагдаж, одоогоор эрчим хүчний доголдол, саатал гарсан зүйлгүй хэвийн байна.

Аймгийн хэмжээнд 17 сумын 56 багт нийт 8896 малчин болон мал бүхий өрхөд 1.5 сая толгой мал өвөлжихөөр тоологдож, сумдын өвс тэжээлийн нөөцийн бүрдүүлэлт 86 хувь, аймгийн өвс тэжээлийн нөөцийн бүрдүүлэлт 100 хувьтай байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газарт нэвтрүүлсэн Чанарын менежментийн тогтолцооны хэрэгжилтэд магадлан аудитын хийх Стандартчлал, хэмжил зүйн газрын БТБГ-ын ахлах шинжээч, шинжээчийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 12-р сарын 12-13-нд ажиллаж, аймгийн Засаг даргын Тамгын газрын стандартын хэрэгжилтийг хангалттай хэмжээнд хэрэгжиж буйг дурьдаад санал дүгнэлт, зөвлөмжийг өглөө.

Хууль зүй дотоод хэргийн яам, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Нээлттэй нийгэм форумтай хамтран "Эрх зүйн хөтөч" бэлтгэх сургалтыг 12 дугаар сарын 06, 07-ны өдрүүдэд зохион байгуулж, сум, тосгодын Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, Хууль, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн, нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтэн, Насан туршийн боловсролын төвийн багш, ЕБС-ийн нийгмийн ажилтан зэрэг ажил, мэргэжлийн 58 албан хаагч хамрагдлаа.

Мэргэжлийн хяналтын газрын ажил үйлчилгээний талаар

Тайлант сард аймгийн Мэргэжлийн хяналтын газраас шинэ жилийн баяртай холбогдуулан урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хүнсний болон хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхлэгч 8, мал амьтны хүнсний түүхий эд бүтээгдэхүүн худалдаалж буй 13, ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын 15 байгууллагад хяналт шалгалт хийж нийт 114 зөрчил дутагдлуудыг илрүүлсэнээс 83 арилгуулж, Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу хялбаршуулсан журмаар 1 иргэн, 1 аж ахуйн нэгжид 1.300.0 мяган төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ тооцож ажиллалаа.

2019 онд зөрчлийн гомдол мэдээлэл 282 бүртгэж зөрчлийн 10 хэрэг, харьяаллын дагуу 11, хүлээн авхаас татгалзсан 3, 260 зөрчлийг хялбаршуулсан журмаар хуулийн хугацаанд нь аймгийн прокурорын хяналтандор бүрэн шийдвэрлэсэн.

Тус газрын итгэмжлэгдсэн лабораторийн чиглэлээр нийт 24 аж ахуйн нэгжийн 35 дээжинд 141 үзүүлэлтээр шинжилгээ хийхэд 5 аж ахуйн нэгжийн 5 дээж 6 үзүүлэлтээр буюу шинжилсэн дээжийн 14,3 хувь нь эерэг гарлаа.

Стандартчилал, хэмжил зүйн хэлтсийн үйл ажиллагааны талаар

Чанарын менежментийн тогтолцооны олон улсын стандартыг хэлтсийн үйл ажиллагаанд нэвтрүүлснээ баталгаажуулах, гэрчилгээний хугацааг сунгуулахаар хүсэлт холбогдох материалаа СХГ-т хүргүүлсэн бөгөөд 2019 оны 12 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд СХГ-ын БТБГ-ын ахлах шинжээч Л.Золзаяагаар ахлуулсан ажлын хэсэг тус хэлтсийн чанарын менежментийн тогтолцооны хэрэгжилтэд гадаад аудит хийн зөвлөмж өгсөн. Аудитын үр дүнгээр амжилттай дүн үзүүлэн гэрчилгээний хугацааг сунгахаар болов.

Стандартчилал, тохирлын үнэлгээ, баталгаажуулалтын чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

Үйлчилгээний баталгаажуулалт:

Шаамар, Мандал, Ерөө, Жавхлант, Алтанбулаг, Сайхан сумын нийт 13 аж ахуйн нэгж, иргэний 13 үйлчилгээний газарт тохирлын үнэлгээ хийж, 1 супермаркет, 6 хүнсний дэлгүүр, 1 зоогийн газар, 1 кафе, 1 караоке баар, 1 цайны газар, 2 үсчний газарт тохирлын гэрчилгээ олгосон байна.

Бүтээгдэхүүн баталгаажуулалт

Сүхбаатар сумын 7-р баг, “Минжийн бор өтөг” ХХК-ийн үйлдвэрлэсэн хөлдөөсөн бууз, банш, зорсон мах, “Эрчин” ХХК-ийн бууз, банш, царцаамаг, Сайхан сумын “Ган зоо тур” ХХК-ийн үйлдвэрлэсэн “Мон татар” нэрийн эрүүл мэндийн цай, Баруунбүрэн сумын 3-р багийн иргэн Д.Шагдарын үйлдвэрлэсэн “Далх бүрэн” нэрийн 4 төрлийн цайг аймгийн МХГ-ын итгэмжлэгдсэн лабораторит сорилт шинжилгээнд оруулж, шинжээчийн дүгнэлт гаргасан бөгөөд бүтээгдэхүүний сав баглаа боодол, хаяг шошгыг стандартын шаардлага хангасан зөв мэдээллээр хангаж арга зүйн заавар зөвлөмж өгч ажиллав.

Стандартын салбар сан:

Стандартын салбар сангаас 9 аж ахуй нэгж байгууллага, иргэний захиалгын дагуу 4 нэрийн 13 стандартаар хангаж, аргазүйн зөвлөгөө өгч, үйлчилгээ үзүүлсэн байна. Үүнээс 5 аж ахуй нэгж байгууллагад 4 нэрийн 8 стандартын борлуулалт хийсэн.

Хэмжил зүйн лабораторийн ажил, үйлчилгээ

Хэмжил зүйн лабораторийн итгэмжлэлийн хугацааг сунгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөөний дагуу хэмжил зүйн лабораторийн өрөөг тохижуулан, нэгж дамжуулалтын бүдүүвчийг хэмжлийн 5 төрлөөр хийж, шинэчлэгдсэн СИ системийн тодорхойлолтоор самбар хийж байршуулсан. “ЮНИ ГАЗ” ХХК-ий 3 хийн түгээгүүр баталгаажуулсан. 1 ш хэмжээт саванд шалгалт тохируулга хийж, худалдаа, үйлчилгээний газруудын 24 жин шалган баталгаажуулсан. Массын хэмжлийн төрлөөр Мандал сумын нэгдсэн эмнэлгийн лабораторийн 1 электрон жинд шалгалт

тохируулга хийлээ. Мөн айл өрх, аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй 1 фазын 100 гаруй цахилгааны тоолуурыг шалган баталгаажуулсан.

Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

Аймгийн ИТХ-ын ээлжит хурлаар аймгийн 2020 оны төсвийг төслийг хэлэлцүүлэн батлуулж, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр аймгийн web сайт, шилэн данс болон ил тод самбарт байршуулан ажиллаж байна. Мөн төрийн сангийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор Сүхбаатар, Баянгол сумдын төрийн сангийн дотоод үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн.

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1. Орон нутгийн төсвийн нийт орлого		71.976.492.1	69.759.890.1	96.9
1.1	Орон нутгийн төсвийн орлого	19.630.713.4	18.351.950.1	93.5
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	15.072.263.2	13.419.957.3	89.0
	Сумдын төсвийн орлого	4.558.450.2	4.931.992.8	108.2
1.2	Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	4.498.427.7	4.498.427.7	100.0
1.3	Улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлэг	40.827.427.7	40.827.427.7	100.0
1.4	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг	5.192.818.8	4.937.210.0	95.1
1.5	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/			
1.6	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/	131.825.9	131.825.9	100.0
1.7	Төсөвт байгууллагын өөрийн орлого	333.420.5	193.675.6	58.1
1.8	Сум хөгжүүлэх сан /орлого/	1.361.858.1	819.373.0	60.2
2. Орон нутгийн төсвийн нийт зарлага		84.584.585.9	77.526.767.4	91.7
2.1	Орон нутгийн төсвийн нийт зарлага	84.584.585.9	77.526.767.4	91.7
	Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага	62.686.582.2	57.104.730.1	91.1
	Сумдын орон нутгийн хөгжлийн сан	2.249.866.9	1.712.942.9	76.1
	Сумдын сум хөгжүүлэх сан	1.200.512.7	265.932.0	22.2
	Аймгийн шууд харьцдаг байгууллагуудын зарлага	24.489.305.2	21.678.184.8	88.5
	Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт	600.000.0	416.195.9	69.4
	Аймгийн замын сангийн хөрөнгө оруулалт	549.000.0	213.679.6	38.9
	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	2.697.865.2	2.119.814.5	78.6
	Халамжийн сан	348.690.0	174.970.0	50.2
	Шууд харьцдаг төсвийн байгууллагуудын зарлага	20.642.440.0	18.753.524.7	90.8
	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө	317.800.0	317.180.3	99.8
	Сумдын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	45.645.3	42.873.9	93.2
	Аймгийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	804.177.1	786.313.4	97.8
	3. Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг		53.300.754.4	52.660.872.8
3.1	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	12.343.230.5	11.703.348.9	94.8
3.2	Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	2.321.361.8	2.447.720.0	105.4
	Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд	129.563.5	129.563.5	100.0
	Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд			
	Хөрөнгө оруулалтын зардалд	2.191.798.3	2.318.156.5	105.8
3.3	Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн	3.039.015.8	2.489.490.1	81.9

	орлогын шилжүүлэг			
	Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд	2.697.865.2	2.148.339.5	79.6
	Усны татаас	21.650.6	21.650.6	100.0
	Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд	319.500.0	319.500.0	100.0
3.4	Сумдад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	40.085.392.1	40.085.392.1	100.0
3.5	Аймагт олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	742.568.3	742.568.3	100.0
	Тусгай зориулалтын шилжүүлэг /салбараар/	40.827.960.4	40.827.960.4	100.0
3.6	- Ерөнхий боловсролын сургууль	21.953.949.4	21.953.949.4	100.0
	- Хүүхдийн цэцэрлэг	11.878.746.9	11.878.746.9	100.0
	- Эрүүл мэндийн байгууллага	6.137.132.7	6.137.132.7	100.0
	- Газрын кадастрын байгууллага	426.997.2	426.997.2	100.0
	- Хүүхдийн байгууллага	431.134.2	431.134.2	100.0
4. Тусгай сангуудын зарлага				
4.1	Сумдын сум хөгжүүлэх сан	1.361.858.1	819.373.0	60.2

2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл		2018 11- сар	2019 11- сар	<u>2019- 11</u> <u>2018-11</u> Х/төгрөгөөр/
1.ХҮНСНИЙ БАРАА				
1 ТАЛХ, ГУРИЛ, БУДАА				
	Гурил /савласан, кг/	1 100	1 200	109.1
	Талх /орон нутгийн, ш/	1 100	1 200	109.1
	Нарийн боов /кг/	2 500	2 500	100.0
	Будаа /кг/	2 400	2 400	100.0
	Элсэн чихэр /кг/	2 200	2 200	100.0
2 МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН				
	Хонины мах /кг/	5 500	7 800	141.8
	Үхрийн мах /кг/	6 500	8 500	130.8
	Адууны мах /кг/	5 800	7 000	120.7
	Ямааны мах /кг/	5500	6 500	127.3
	Дотор мах, цувдай /цусгүй/	3000	4 000	133.3
	Хиам /чанасан, кг/	10 000	10 000	100.0
3 СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ				
	Сүү /задгай, л/	900	1 000	111.1
	Сүү / савласан, л/	2 600	2 700	103.8
	Тараг /задгай, л/	1 200	1 300	108.3
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	13 000	15 000	115.4
	Айраг /л/	3 500	3 500	100.0
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	4 500	4 500	100.0
	Өндөг /ш/	350	350	100.0
4 БҮХ ТӨРЛИЙН ӨӨХ ТОС				
	Ургамлын тос /л/	3 800	3 800	100.0
	Өөхөн тос /кг/	2 000	2 000	100.0
	Шар тос /кг/	13 000	13 000	100.0
	Масло /задгай, кг/	4 500	4 500	100.0
5 ХҮНСНИЙ НОГОО				
	Төмс /кг/	800	800	125.0
	Лууван /кг/	1000	1 100	110.0
	Манжин /кг/	1000	1500	150.0
	Байцаа /кг/	1000	1200	120.0

	Сонгино /кг/	1200	1500	125.0
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	3 500	3 500	100.0
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	2 300	2 800	121.7
7	ШАТАХУУН			
	Бензин А - 80	1 645	1 750	106.4
	Бензин А - 92	1 795	1 840	102.5
	Дизелийн түлш	2 105	2 370	112.6

Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

Аймгийн хэмжээнд 2019 оны 11 дүгээр сард 527 холбогдогчтой 2121,6 сая төгрөгийн хохиролтой, 720 гэмт хэрэг бүртгэгдэж урьд оны мөн үеэс 4 хэргээр буюу 0,5 хувиар буурчээ. Гэмт хэрэг бүртгэгдэж урьд оны мөн үеэс 2,6 хувиар өссөн байна.

Улсын бүртгэлийн хэлтсээс 12 дугаар сард газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ 203 бичиж, 4 лавлагаа, газраас бусад үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээ 106 бичиж, 22 лавлагаа өгч үйлчиллээ.

Олон Улсын хүний эрхийн өдрийг тохиолдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын орон нутаг дахь төлөөлөл, Монголын Хуульчдын Холбоо, Монголын Өмгөөлөгчдийн Холбоо, Хууль зүйн туслалцааны төвтэй хамтран иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөө өгөх өдөрлөгийг 12 дугаар сарын 10-ны өдөр иргэний танхимд зохион байгуулан ажилласан. Энэ арга хэмжээний үеэр Хүний эрхийн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх, сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулахаар төлөвлөн, Сүхбаатар сумын 23 хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд “Хүний эрхийн тухай ойлголт” сэдвээр сургалт зохион байгуулсан.

Орхон аймагт зохион байгуулагдсан “Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүдийг чадавхийг бэхжүүлэх бүсийн сургалт”-д 12-р сарын 13-ны өдөр хэлтсийн ахлах мэргэжилтэн оролцоод ирсэн. Сургалтад Орхон, Дархан, Булган, Хөвсгөл, Сэлэнгэ аймгууд хамрагдаж, ХЭХЗХ-ний албан бланк, тамга тэмдэг, ном гарын авлагыг тараасан.

Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдөр Улаанбаатар хотод МУИС-ХЗС, “Отгонтэнгэр”, “Их Засаг”, “Шихихутуг” зэрэг хууль зүйн их, дээд сургуулийн клиник сургалтын төвийн багш нарыг хамруулан “Иргэдийн эрх зүйн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэхэд хууль зүйн их, дээд сургуулийн клиник төвүүдийн хамтын ажиллагаа, орон нутагт хамтран ажиллах боломж” сэдвээр уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, санал солилцсон.

Баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд Сэлэнгэ аймгийн банкны контор, Мал эмнэлэгийн газар, ХААУГ, Арилжааны банкны 4 хөмрөгийн 64 хадгаламжийн нэгжний 5250 хуудас баримтын мэдээллийн агуулгыг уншиж заалт 4434, хүний нэр 13109, байгууллагын нэр 2195, газар зүйн нэр 2584 шивж эх баримттай холбох ажлыг хийж гүйцэтгэсэн. Мал эмнэлэг, Хөдөө аж ахуйн удирдах газрын хөмрөгийн 25 хадгаламжийн нэгжний 1384 хуудас баримтыг скайнердаж мастер хувь үүсгэсэн. Дээрх мастер хувь үүсгэсэн баримтуудыг хард болон DVD дээр хуулж нөөц ба ашиглалтын хувь үүсгэсэн. Аймгийн Банкны конторын хөмрөгийн 1964-2002 оны 175 ХН, Барилга угсралтын конторын хөмрөгийн 1959-1990 оны 109 хадгаламжийн нэгжид хэсэгчилсэн тооллого хийж иж бүрэн нягтлан шалгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн дансны бүрдэл болох түүхчилсэн лавлах, шилжүүлэх хүснэгт, баримтын түүх, нэр төрлийн заагуур, устгах хэргийн акт, дансны шинэчилсэн бүртгэл зэргийг боловсруулсан.

Иргэд албан байгууллагын хүсэлтийн дагуу архивын лавлагаа цахим хэлбэрээр 172, мастер хувиас 68, цаасан суурьтай баримтнаас 30, магадлагаа, тодорхойлолт 38, цалингийн тодорхойлолт 2-ыг тус тус гаргаж үйлчилсэн.

Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

1.Боловсрол, соёл урлаг, спортын чиглэлээр

Боловсролын салбар дахь залуу, дунд, ахмад үеийн залгамж холбоог бэхжүүлэх, залуу багш, удирдах ажилтнуудын ажлын дадлага туршлага, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, дадлагажуулах, зөвлөгөө дэмжлэг үзүүлэх зорилгоор “Ахмадын зөвлөх үйлчилгээний баг” Ерөө, Хараа бүсийн сургууль, цэцэрлэгүүдэд зөвлөн туслах чиглэлээр ажиллаж, багш, удирдах ажилтнуудад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгсөн.

Монгол Улсад атар газар эзэмшсэний 60 жилийн ойг тохиолдуулан хойч үе, хүүхэд багачуудад танин мэдүүлэх, бахархан дуурайх үзэл хандлагыг төлөвшүүлэх зорилгоор дунд, ахлах ангийнхны дунд ахмад атарчид, анхдагчид, хувь нэмрээ оруулан ажилласан хүмүүстэй уулзалт, ярилцлага хийх, өөрийн нутаг орон, үйл явдлыг танилцуулах өдөрлөг зохион байгуулах, эсээ, зохион бичлэгийн болон гар зургийн уралдаан зохион байгуулж, эцэг эх, олон нийтэд танилцуулах, сурталчлах зэргээр өөрийн сургуулийн онцлог, нөөц, боломжид тулгуурласан ажлуудыг зохион байгуулсан.

Монгол Улсын Боловсролын их сургуулиас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Мультимедиа програм хангамжийг сургалтанд хэрэглэх, хөгжүүлэх нь" үндэсний XII уралдааны удирдамжийн дагуу эхний шатнаас шалгарсан дараах 4 цахим хэрэглэгдэхүүнт хичээлийг улсын комисст хүргүүлж Цагааннуур сумын ЕБС-ийн хими биологийн багш С.Баярсайхан улсад 1-р, Орхон сумын ЕБС-ийн Байгалийн ухааны багш нар 3-р байранд шалгарсан амжилт гаргасан.

“Суурь боловсролын чанарыг ахиулахад мэдээллийн технологийг оновчтой ашиглах” төслийн хүрээнд “Туршилт хэлэлцүүлэг” сургалтаар хэлэлцүүлсэн 6 цахим хичээлийн сайжруулсан хувилбарыг МУБИС-ийн мэргэжлийн багт хүргүүлсэн.

Дэлхийн Зөн монгол орон нутгийн хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилтээр "Хүмүүжлийн эерэг арга" сэдэвт сургалтыг Орхон, Ерөө бүсийн 65 багшид зохион байгуулсан.

Аймгийн аварга шалгаруулах өсвөр үе, насанд хүрэгчийн Чөлөөт бөхийн тэмцээнийг зохион байгуулж нийт 22 байгууллагын 308 тамирчин 35 жинд өрсөлдсөн бол Өсвөр үеийн чөлөөт бөхийн барилдаанд 200 тамирчин 15 жинд өрсөлдлөө. Мөн Самбо бөхийн өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж нийт 11 багийн 220 гаруй тамирчид оролцсоноос гадна самбо бөхийн Спортын мастер, Монгол Улсын 5 удаагийн аварга Шуурайн Батболдын нэрэмжит жү-до бөхийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнд нийт 11 байгууллагын 190 гаруй тамирчид хурд хүчээ сорин өрсөлдлөө.

Олон улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан урлаг спортын өдөрлөг зохион байгуулж арга хэмжээнд Сайхан, Ерөө, Алтанбулаг, Жавхлант, Сүхбаатар, Цагааннуур, Жавхлант, Мандал зэрэг сумдаас ирсэн 100 гаруй тамирчид оролцсон.

"Атар газар эзэмшсэний 60 жилийн ой"-г тохиолдуулан ахмадуудын дунд хийн дасгал,шагайн наадгайн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж нийт 18 сумын баг тамирчид шагай няслах, морь уралдах, шагай шүүрэх, хийн дасгал, гангараа дасгал гэсэн төрлүүдээр өрсөлдөж, багийн дүнгээр 1-р байрт Сүхбаатар сумын баг тамирчид, 2-р байрт Сайхан сумын баг тамирчид, 3-р байр Баруунбүрэн сумын баг тамирчид шалгарсан.

2.Эрүүл мэндийн чиглэлээр

Халдварт болон халдварт бус өвчнийг эрт илрүүлэх цогц үзлэг оношилгооны 2 дах шатны үзлэгийг Хэрх тосгонд зохион байгуулж1024иргэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хүргэж “Мэдээллийн цахим сан”-д баяжилт хийсэн.

Эрт илрүүлгийн үзлэг оношилгоонд дотор, зүрх судас, дотоод шүүрэл, эмэгтэйчүүд, мэдрэл, чих хамар хоолой, эрэгтэйчүүд, сэтгэц, шүд, охид, хөвгүүд,

нүдний гэх мэт нарийн мэргэжлийн эмч нар үзлэг хийж, зөөврийн дижитал рентген аппаратаар цээжний хөндийн эмгэг илрүүлсэн бол ЭХО аппаратын тусламжтайгаар дотрын болон эмэгтэйчүүдийн эмгэг өөрчлөлтүүдийг оношилсон.

“Communities make the difference буюу Өөрчлөлтийг та бид хийнэ” уриан дор аймгийн хэмжээнд Дэлхийн нийтээрээ ХДХВ/ДОХ-ын асуудалд анхаарал хандуулах өдрийг угтан жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Волейболын тэмцээн, алтан хонх, гар зургын уралдаан, уриалга самбар хийх, мөн сургалт сурталчилгаа, мэдээ мэдээлэл өгөх, гарын авлага, бэлгэвч тараах ажлыг зохион байгуулж нийт 3000 гаруй иргэд, хүүхэд залуучууд хамрагдсан

ДОХ/ХДХВ илрүүлэх түргэвчилсэн оношлуураар 440 гаруй хүнд шинжилгээ тавьж ажилласан. “Тэмбүүг устгая” үйл ажиллагааны дагуу сум, тосгон, өрхийн Эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтэн нийт 34 хүнд тэмбүүгийн оношилгоо, эмчилгээ, хяналтыг сайжруулах онол дадлага хосолсон сургалт зохион байгуулсан.

“Сүрьеэгүй Сэлэнгэ” хөтөлбөрийг эрчимжүүлэх зорилгоор ОЭТС-ийн эмчилгээ хяналтыг сайжруулах зорилгоор сүрьеэгийн мэргэжлийн эмч нар, орон нутгийн сүрьеэгийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд нийт 41 хүнд ХӨСҮТ-ийн сүрьеэгийн клиникийн эмч нар онол дадлага хосолсон сургалт зохион байгуулсан.

Сүхбаатар сумын 4, 5, 7, 8-р багийн сүүлийн 5 жилийн сүрьеэгээр өвдөгсөд түүний өрх болон ойрын хавьтал, эрсдэлт бүлгийн хүн амд сүрьеэ илрүүлэх үзлэг оношилгоог “Номтхан” Өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран харъяаллын дагуу хорооллын өрхийн эмнэлгийн байр, төмөр замын клуб, шүдэнзний арын өрхийн эмнэлгийн байр, ПСМК-ийн багийн даргын байранд тус тус цэг дээр байрлан нийт 714 хүн үзэж цэрний шинжилгээ өгөх шаардлагатай 4 хүн гарсан.

Цагааннуур, Түшиг, Зүүнбүрэн, Баруунбүрэн, Сант сум Номгон тосгоны эрүүл мэндийн төвүүдэд дэмжлэгт хяналтыг зохион байгуулж 6 эрүүл мэндийн төвд эмнэлгийн тусламж үйлчилгээний 11 чиглэлээр үнэлж үзэхэд: Үнэлгээний нэгдсэн дүнгээр 6 эрүүл мэндийн төв дунджаар 57 хувьтай байна. Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй хамтран 2019 оны 12 сард 6 эрүүл мэндийн байгууллагад магадлан итгэмжлэлийн явцын хяналт үнэлгээг хийсэн.

Үнэлгээний дүнд: 1. Аймгийн нэгдсэн эмнэлэг-77,8 хувь, 2. Сайхан сум дундын эмнэлэг-71,6 хувь, 3. Чих хамар хоолойн Эбус эмнэлэг-51,2 хувь, 4. Хүдэр сумын Эрүүл мэндийн төв-75 хувь, 5. Шаамар сумын эрүүл мэндийн төв-54.5 хувь, 6. Нямзул эмнэлэг-86 хувьтай тус тус үнэлэгдсэн.

3.Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний талаар

2019 оны 11-р сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй 653 байсан бол 140 иргэн шинээр бүртгүүлж, ажил олгогчоос ирүүлсэн 97 ажлын байранд 89 хүнийг ажилд зуучилж, идэвхигүйн улмаас 64 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 640 болсон байна.

Халамжийн сангаас нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж хөнгөлөлтийн үйлчилгээг зорилтот бүлэгт түргэн шуурхай, хүнд сурталгүй чанартай хүргэх, халамжийн шинэ үйлчилгээг нэвтрүүлэхэд төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцоотойгоор 17 сум 6 тосгоны 39 мэргэжилтнүүд төрийн үйлчилгээг хүргэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд халамжийн санд улсын төсвөөс 14.733.326,5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 262175,0 мянган төгрөг, нийт 14.995.501,5 мянган төгрөгийн төсөв батлагдсан.

Орон нутгийн төсвийн орлогоос: 2019 онд халамжийн санд орон нутгийн төсвөөс 262175,0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас тайлант хугацаанд 471 иргэнд 175270,0 мянган төгрөгийг олгоод байна. Үүнд:

-Онцгой тохиолдлын тэтгэмжид 83 иргэнд 99600,0 мянган төгрөг

-Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 388 иргэнд 75670,0 мянган төгрөг

Улсын төсвийн орлогоос: Халамжийн санд улсын төсвөөс 14.733.326,5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас тайлант хугацаанд 47444 иргэнд 4.843.180,6 мянган төгрөгийг олгоод байна.

4.Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар

Хүүхдийн тусламжийн 108 утсаны үйлчилгээний төвөөс шилжин ирсэн 6 дуудлагыг хяналтандаа авч, хамтарсан баг хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлсэн. Дуудлагыг хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэлбэрээр нь ангилбал:

- Бие махбодын хүчирхийлэл 1
- Сэтгэл санааны 5 дуудлага байна.

“Оны онцлох хүүхэд” шалгаруулах үйл ажиллагаанд 10 сумын 28 ерөнхий боловсролын сургуулиас 60 сурагчийн материал ирүүлснээс өөрийн мэдлэг, авьяас, хичээл зүтгэлээрээ тэргүүлэн сурлага, спорт, урлаг болон бусад төрлөөр амжилт гарган манлайлсан 9 хүүхдийг тодруулсан. Үүнд:

1.Техник сэтгэлээ, шинэ санал, санаачилга, бүтээлч байдал номинацид Мандал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 11-а ангийн сурагч Х.Манлайбаатар

2. Сурлагын амжилт номинацид Мандал сумын Билиг ДБ 12 а- ангийн сурагч Б.Мөнхжаргал

3. Урлаг уран бүтээл номинацид Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 6-б ангийн сурагч Л.Үүрийнцолмон

4. Биеийн тамир спортын номинацид Мандал сумын Ерөнхий боловсролын 4-р сургуулийн 11а- ангийн сурагч Ч.Элбэг,

5.Ерөө сумын Ерөнхий боловсролын сургуулийн 6 б-ангийн сурагч О.Одбаяр

6.Эх орны түүх, соёл өв уламжлал номинацид Сайхан сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 12 а-ангийн сурагч Т.Хашболд

7. Хүмүүнлэг, энэрэнгүй сайн үйлс номинацид Мандал сумын Түнхэл тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 11 а – ангийн сурагч Н.Хулан

8. Хүүхдийн өөрийн удирдлагын байгууллага номинацид Ерөө сумын Бугант тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 12 а- ангийн сурагч Б.Пүрэвдулам

9. Багийн амжилт номинацид Сайхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 12 б- ангийн “Титэм” баг сурагч Б.Болормаа, Э.Буянзаяа, Д.Дэлгэрмаа нар тус тус шалгарсан.

Залуучуудын хөгжлийн төвөөс Амьдрах ухааны сургалтын модулийг боловсруулан Шаамар сум дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн оюутнуудад “Мэргэжил сонголт”-ын талаар сургалт нөлөөллийн ажил зохион байгуулж 90 оюутан оролцсон.

Гэр бүлийн төлөө “Ойлгоё хүндэлье” 16 хоногийн аяны хүрээнд Сэлэнгэ хүүхэд фэйсбүүк хуудсаар дамжуулан 3 төрлийн видео мэдээ, 6 төрлийн нөлөөллийн хуудас байршуулсанаас 157 лайк дарагдаж 59 хэрэглэгчийн хуудсанд байршуулж ажиллалаа.

“Хүүхдийн хөгжил, оролцооны хүүхдийн өөрөө удирдах байгууллага, оролцооны клубуудийн үйл ажиллагааг дэмжиж, хүүхдийн оролцох үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хангах арга хэмжээ зохион байгуулах” ажлын хүрээнд 6 хүүхдийн өөрөө удирдах байгууллага, клубийг дэмжих үйл ажиллагааг зохион байгууллаа. Үүнд:

-Орхонтуул сумын Хүүхдийн ордны дэргэдэх “Бид өглөөний хүн” клубийн “Бид өглөөний хүн – Бид номын найз” төсөл.

-Сүхбаатар сумын 6-р сургуулийн “Охидын клуб” клубийн “Үйл ажиллагааг эрчимжүүлэх” төсөл.

-Сүхбаатар сумын 6-р сургуулийн “Лидер сурагч” клубийн“Гэрэлт ирээдүй” сайн үйлсийн аян төсөл.

-Мандал сумын Хүүхдийн ордны дэргэдэх “Хүслийн хөтөч” клубийн “Эх дэлхийгээ хайрлахад ирээдүйн иргэний оролцоо” бага насны хүүхдүүдэд амьдрах ухааны боловсрол олгох төсөл.

-Мандал сумын 2-р сургуулийн “Өсвөрийн сэргийлэгч” клубийн “Хорт зуршлийн хор нөлөө” төсөл

-Мандал сумын 2-р сугуулийн “Охидын клуб”-ийн “Эерэг хандлагаар манлайлъя” төсөл тус тус шалгарсан.

5.Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ажил үйлчилгээний талаар:

Нийгмийн даатгалын хэлтэс нь 2019 оны 12 дугаар сарын байдлаар 35,6 тэр бум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөтөйгээс 12 дугаарсарын 25-ны байдлаар өссөн дүнгээр37,3 тэр бум төгрөгний орлого төвлөрүүлж 104,6 хувийн биелэлттэй ажилласан.

Тэтгэврийн даатгалын сангаас 16917 тэтгэвэр авагчдад 64690792 сая төгрөгийг тэтгэвэрт, Тэтгэмжийн даатгалын сангаас 6991 хүнд 2927593 сая төгрөгийг хөдөлмөрийн чадвараа түр алдсан, жирэмсэн амаржсан, оршуулгын тэтгэмжид, Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас үйлдвэрлэлийн ослын тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, нөхөн төлбөр, сувиллын зардалд 285 хүнд 1062151 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 536 хүнд 801521 сая төгрөгийг ажилгүйдлийн тэтгэмжид тус тус олгосон.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссоор 2019 оны 12 сард нийт 4 хурал хийж 357 хүнээс, 19 хүнийг цуцалж, 49 хүн шинээр тогтоолгосон, 289 хүн актаа сунгуулсан байна.

Архивын лавлагааг 2019 оны 12 дүгээр сарын 21-ний байдлаар 1350 лавлагааг гаргасан. Нийгмийн даатгалын хэлтсээс Сэлэнгэ аймгийн Сүхбаатар суманд 2019 оны 12 дугаар сарын 10-18-ны өдрүүдэд "Нийгмийн даатгал-Бидний ирээдүй" сургалт зохион байгуулж 273 сурагч оролцож, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж, эрүүл мэнд, сайн дурын даатгалын талаар мэдээлэл өгч ажилласан.

Тав.Үйлдвэр, хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:

2019 онд улаанбуудайн урамшуулалд хамруулах аж ахуйн нэгжийн материалыг сумдаас хүлээн авч, 204 иргэн аж ахуйн нэгжийн материалыг бүрдүүлэн Тариалан эрхлэлтийг дэмжих санд хүргүүлсэн.

Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яамнаас Монголын уламжлалт хоол, идээ, ундааг сурталчлах тогоочдын ажил мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор “Улсын аварга тогооч” шалгаруулах ажил мэргэжлийн уралдаан 2019 оны 12 дугаар сарын 05, 06-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдаж, Ерөө, Цагааннуур, Мандал сумдын 4 тогооч оролцсноос “Хүүхдийн хоолны төрөл”-д Ерөө сумын Ерөнхий боловсролын сургуулийн ахлах тогооч К.Түмэнжаргал “Тусгай байр” эзэлж амжилттай оролцлоо.

Жилийн эцсийн мал тооллогогыг зохион байгуулахтай холбоотойгоор Статистикийн хэлтэстэй хамтран 17 сумын тооллогын комисст тооллогын ажлыг үр дүнтэй чанартай хийж гүйцэтгэх, тэр дундаа цэвэр эрлийз малыг тоолох программд шивэхдээ хэрхэн үнэн зөв оруулах талаар сургалт зохион байгууллаа.

Мал тооллогын ажилд хяналт тавих зорилгоор Статистикийн хэлтэс болон ХХААХҮЯ-аас томилогдсон ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэй Түшиг, Цагааннуур, Зүүнбүрэн, Шаамар, Алтанбулаг, Ерөө, Сайхан сумдад ажиллаж хяналтын тооллого хийж гүйцэтгэлээ. Тооллогын явцад илэрсэн зөрчилгүй малыг толгой дараалан тоолсон, маягтыг нэг бүрчлэн хөтөлсөн байсан.

Мал зүйчдийн улсын зөвлөгөөнд 17 сумын хөдөө аж ахуйн тасгийн мал зүйчид болон ахмад мал зүйч, мал үржүүлэг технологийн нэгжийн мал зүйч нийт 26 хүний бүрэлдэхүүнтэйгээр оролцсон.

Зургаа. Хөрөнгө оруулалт, газрын харилцаа, барилга хот байгуулалтын чиглэлээр:

Сүхбаатар сумын инженерийн шугам сүлжээ бүхий газарт эрх баталгаажуулах 4 иргэн, газар эзэмших эрхээ бусдад шилжүүлэх 21 иргэн, эрхийн гэрчилгээний хугацаа сунгуулах хүсэлт гарсан 2 иргэн, эзэмшил газраа хэсэгчилэн шилжүүлэх хүсэлт гаргасан 2, шинээр газар өмчлөхийг хүссэн 10, шинээр газар эзэмших хүсэлт гаргасан 13, 2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд хүсэлт гаргасан 28, газар эзэмших эрхийн Э дугаар авах хүсэлт гаргасан 39 иргэний өргөдөл хүсэлтийг хүлээн авсан. Аймгийн Засаг даргын захирамжаар 7 иргэний газар эзэмших эрхийг шилжүүлж, 5 иргэний газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгаж, 2 иргэний газар эзэмших эрхийг баталгаажуулж хуулийн хугацаанд өргөдөл хүсэлтийг тус тус шийдвэрлэв. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д зааснаар 34 иргэн, 1 аж ахуйн нэгжийн 13 нэгж талбарын газар эзэмших эрхийн гэрчилгээнд Э дугаар авах хүсэлтийг дундын мэдээллийн сангаар дамжуулан Улсын бүртгэлийн хэлтэст илгээв. Тус сард 36 иргэн, 1 аж ахуйн нэгжийн нийт 49 газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулан газар эзэмшигчийн улсын бүртгэлд бүртгэж баталгаажуулсан. Сэлэнгэ аймгийн Газар зүйн нэрийн салбар зөвлөлийг аймгийн Засаг даргын 2019.12.03-ны өдрийн А/429 дүгээр захирамжаар байгуулсан. Үүнд: хөгжлийн асуудал хариуцсан аймгийн Засаг даргын орлогчоор зөвлөлийг даргалуулж, 15 байгууллагын төлөөллийг гишүүдээр томилсон ба төрийн бус байгууллагын төлөөллийг оролцууллаа

Газрын төлбөрийг газрын кадастрын нэгдсэн мэдээлэлийн систем “ВЭБ”-д холбох ажлын хүрээнд нийт 16094 нэгж талбарын мэдээлэлийг холбож, 9740 нэгж талбарыг шинэчилсэн болон хүчинтэй төлөвт бүртгэж газрын төлбөрийн мэдээллийн бүрэн оруулаад байна. Мөн газрын кадастрын мэдээлэлийн санд зөрчилтэй буюу давхардсан гэрээ холбогдсон 6590 нэгж талбарын мэдээлэлийг засварлуулахаар ГЗБГЗЗГазрын Кадастрын хэлтэст хүргүүлээд байна.

2019 онд газрын төлбөрийн орлогын гүйцэтгэл болох 420530.0 сая төгрөгийг биелүүлж, 157.695.000 төгрөгийг давуулан биелүүлж төсөвт төвлөрүүлэн ажиллалаа.

Долоо. Байгаль орчны чиглэлээр

“Байгалийн ургамал түүж бэлтгэх төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолын төслийг боловсруулан аймгийн ИТХ-аар батлуулсан.

“Байгаль хамгаалагчдын нэгдсэн зөвлөлгөөн”-ийг 2019 оны 12 дугаар сарын 18-19-ний өдрүүдэд зохион байгуулж 2019 оны үйл ажиллагаагаа дүгнэж 2020 оны ажлыг төлөвлөсөн. Зөвлөлгөөнд сумын болон сум дундын Ойн ангийн инженер техникийн болон байгаль хамгаалагч нийт 65 ажилтан албан хаагчид оролцсон.

БОАЖЯ-тай хамтран “Ойн ашиглалтанд тавих хяналтыг эрчимжүүлэх” сэдэвт зөвлөгөөнийг зохион байгуулж, сумдын болон сум дундын Ойн анги, ойн мэргэжлийн байгууллага ойн мэргэжлийн байгууллагын төлөөлөл 107 албан хаагчийг оролцууллаа.

Найм.Сум орон нутгийн ажил үйлчилгээний талаар:

Баруунбүрэн сум:

Атар газар эзэмшсний 60 жилийн ойн баярын хүрээнд 12 сарын 19-нд гар бөмбөг, дартсны тэмцээн, 12 сарын 20-нд бөхийн барилдаан, “Атарчдын уянга” дууны уралдаан, 12 дугаар сарын 21-нд баярын хурал, баярын концерт, хүлээн авалт зэрэг ажлуудыг амжилттай зохион байгууллаа. Мөн атар газар эзэмшсний 60 жилийн ойд зориулсан баримтат киног ирсэн зочиддоо 108 ширхэгээр багцалсан тариан түрүүтэй хамт гарын бэлэг болгон дурсгалаа. Атар газар эзэмшсний 60 жилийн ойн хүрээнд Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одонгоор 2 иргэн, алтан

гадас одонгоор 13, хөдөлмөрийн хүндэт медалиар 10, атарчдын алдар медалиар 25, хүнс, хөдөө аж ахуйн тэргүүний ажилтнаар 45, хүнс, хөдөө аж ахуйн яамны жуух бичгээр 25 иргэн тус тус шагнагдлаа.

Жилийн эцсийн мал тооллогын дүнгээр тэмээ 21, адуу 10134, үхэр 15420, хонь 86450, ямаа 60548 нийт 172573 толгой мал тоологдсон нь урьд оныхоос адуу 2039 толгой, үхэр 31 толгой, хонь 1415 толгой, ямаа 4268 толгой 5948 толгой буюу 3,6%-иар өссөн дүнтэй байна.

ОБСД-ын ойн анги нь Ойн мэргэжлийн байгууллага болох “Шинэ орос хийц” ХХК-д Уртын ам, Бургалтайд үндсэн ашиглалтын огтлолтоор хоёр удаагийн талбай тусгаарлалт хийж 40 га талбай тусгаарлалт хийлээ.

Тайлант сард цэцэрлэгт хамран сургах тойргийн /сарын турш/ 3680 хүүхэд хамрагдахаас 2834 хүүхдийг 77%-тай хамрагдуулан ажиллалаа. Томуу томуу төст өвчний дэгдэлт маш их байгаа тул хүүхдийн тоо буурч өвчлөл нэмэгдсэн байна.

Сумын төр, төсвийн байгууллагуудын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

Мандал сум:

“Атар-60 жилийн ой, Ургацын баяр-2019” арга хэмжээг зохион байгуулж, Зүүнхараа Сангийн аж ахуйн суурин дээр үүссэн Хэрх тосгонд, Мөнгөн хараа Дуу бүжгийн чуулгад Баярын хурал, хүндэтгэлийн тоглолтонд 500 гаруй зочид, анхны атарчид, ахмад тариаланчид, газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ууд, тариаланчид, ногоочид оролцож, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 4, Алтан гадас одонгоор 12, Хөдөлмөрийн хүндэт медалиар 6, Атарчдын алдар медалиар 28, Хөдөө аж ахуй хүнсний үйлдвэрийн тэргүүний ажилтан цол тэмдгээр 26, Яамны жуух бичгээр 18, Сэлэнгэ аймгийн Засаг даргын жуух бичгээр 2, Сумын Засаг даргын жуух бичгээр 14, Атар 60 жилийн улсын ойн медалиар 270, аймгийн ойн медалиар 70 иргэний хөдөлмөр зүтгэлийг үнэлж шагналаа.

Сумын амьжиргаа дэмжих зөвлөл тайлант сард 2 удаа хуралдаж байнгын асаргаанд шинээр хамрагдах, сунгалт, тэжээгчийн тэтгэвэр сунгалт зэрэг 40 иргэний өргөдлийг шийдвэрлэв.

Байнгын асаргаатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн шинэ жилийн баярын үйл ажиллагааг Нарны өртөө ресторанд зохион байгуулж 36 хүүхдийг хамрууллаа.

Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд хүнсний эрхийн бичгээр үйлчилгээ үзүүлдэг “Буд”, “Цэцэн хайрхан”, “Төөнт” дэлгүүрүүдтэй хамтран 12 өрхийн 27 хүүхдэд шинэ жилийн баярын бэлэг гардууллаа.

Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор жижиг зээлд хамрагдах иргэний бүртгэлийг хүлээн авч, мэдээллийн сан бүрдүүлэн ажиллаж, 12-р сард өссөн дүнгээр 35 иргэн бүртгэлд хамрагдсан боловч энэ жилийн зээл олголт зөвхөн аймгийн төвийн суманд хэрэгжихээр болсон.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “ж”, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5-д тус тус зааснаар Сэлэнгэ аймгийн Засаг дарга аймгийн нутаг дэвсгэр дэх худалдаа үйлчилгээний газрын үйл ажиллагаа эрхлэх цагийн хуваарийг баталж, мөрдүүлэхтэй холбогдуулан санал авах ажлын хүрээнд сумандаа нийт худалдаа үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын дунд 2019 оны 12 дугаар сарын 18-ний өдөр сургалт зохион байгуулж, хэлэлцүүлэг өрнүүллээ. Энэхүү хэлэлцүүлэгийн үеэр Сэлэнгэ аймгийн Стандарт Хэмжил Зүйн хэлтсийн дарга Д.Ган-Отгон, баталгаажуулалтын ахлах шинжээч Л.Анхцэцэг, Нийгмийн Даатгалын тасгийн дарга Ж.Эрдэнэцогт, Цагдаагийн хэлтсийн Урьдчилан Сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, ахмад Б.Мөнхцэцэг, Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч М.Болормаа нар оролцон 2020 оноос дагаж мөрдөх хууль тогтоомж, худалдаа, хоолны газрын шинэ стандартын талаар нийт худалдаа, үйлчилгээ эрхлэгчдэд мэдээлэл хүргэлээ.

Хэлэлцүүлэгт Мандал сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй худалдаа, үйлчилгээ эрхлэгчдээс 70 иргэн, аж ахуйн нэгж байгууллага оролцов. Оролцсон нийт худалдаа үйлчилгээ эрхлэгчдээс цагийн хуваарийн санал асуулга авч нэгтгэн хүргэлээ. Тус арга хэмжээнд үсчин, гоо сайханчдыг хамруулан шаардлага хангасан 6 иргэн, аж ахуйн нэгжид “Тохирлын гэрчилгээ” олголоо.

Монголын сүү үйлдвэрлэгчдийн холбоо, Зүүнхараа Политехник коллежтэй хамтран Сүүний үхрийн фермерийн аж ахуй эрхлэгч 30 иргэнийг хамруулан Сүүнд урамшууллын хэлэлцүүлэг зохион байгуулж саналаа нэгтгэн, Төрийн ордонд болсон Сүүний аж ахуй эрхлэгчид, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн чуулга уулзалтанд 20 аж ахуй эрхлэгч оролцлоо. Өрхийн үйлдвэрлэгч, Жижиг дунд үйлдвэрлэгч эмэгтэйчүүдийн анхдугаар чуулганд бизнес эрхлэгч 75 эмэгтэйчүүдийг оролцож, санал бодлоо хуваалцаж, цаашдын зорилтоо тодорхойллоо.

Баянсуудалын 3-р баг цэвэрлэх байгууламжийн хойд болон зүүн хэсэгт байрлах цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй айл өрхүүдийн дунд шинээр 160 кВа чадалтай трансформатор барьж, 6 болон 0,4 кВ-ын 67 ширхэг тулгуур босгож, 3,3 км СИП утас татаж, 19 ширхэг тоолуур төвлөрүүлэх хайрцаг суурилуулж ашиглалтад оруулснаар 50 гаруй айл өрхийг эрчим хүчинд холболоо.

2019 онд 37 аж ахуйн нэгж, байгууллага, 198 орон сууцны айл өрх, 2172 гэр хорооллын айл өрхийн нийт 2407 энгийн тоолуурыг ухаалаг 2 тарифт тоолуураар шинэчиллээ. 7-р баг Нэгдсэн эмнэлгийн дөрвөн замын уулзварт Гэрлэн дохио суурилуулж ашиглалтад орууллаа. Мөн 1-р сургуулийн урд замын хяналтын камер суурилууллаа. 2015-2018 онуудад суурилагдаж ашиглалтын явцад эвдрэл гэмтэл гарсан 11 цэгийн 32 ширхэг камеруудын шилэн кабелиудыг засварлаж ашиглалтад орууллаа.

Мод бэлтгэх эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээг 8 нөхөрлөл, 12 ААНБ-д 2391,3 м³ хэрэглээ, 1339,9 м³ түлээ буюу нийт 3725,2 м³ мод бэлтгэх зөвшөөрөл олгож, 4 нөхөрлөл, 17 ААНБ-ийн 1036,2 м³ хэрэглээний, 434 м³ түлээний нийт 1470,2 м³ мод, модон материалд гарал үүслийн гэрчилгээ олгосон.

Баянгол сум

Монгол Улсад атар газар эзэмшиж, газар тариаланг бие даасан салбар болгон хөгжүүлсэний 60 жилийн ойг Баянгол сумын хэмжээнд 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдөр ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүллээ. Баянголчууд Атрын 60 жилийн ойг тэмдэглэж буй энэ өдрүүдэд өнгөрсөн үеэ дурсаж, нэгэн жарны ажлаа дүгнэж, түүнийгээ түүхэнд баталгаажуулан үлдээхийн сацуу тариаланчид, хадланчид, ногоочдын дундаас ахмад тариаланч, анхны атарчин Л.Алтангэрэл Монгол улсын төрийн дээд шагнал “Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одонгоор, Л.Содномдагва, Н.Алтантулга, Т.Заманд, Л.Эрдэнэбаяр, Х.Пүрэвдорж, Д.Сүхбаатар, Б.Алтангэрэл нар Алтан гадас одонгоор, Хөдөлмөрийн хүндэт медалиар Ш.Володъя, Б.Эрдэнээ, Ч.Намжилсүрэн, Л.Мягмардорж, Д.Наранцогт, Н.Лувсандорж, Д.Төмөрбат нар шагнагдаж, 35 тариаланч Атарчдын алдар медалиар, 6 тариаланч Хүнс хөдөө аж ахуйн тэргүүний ажилтан цол тэмдгээр, 3 тариаланч Хүнс хөдөө аж ахуйн яамны Хүндэт жуух бичгээр, 25 ахмад тариаланч Улсын атрын 60 жилийн ойн медалиар, 80 тариаланч Сэлэнгэ аймгийн Атрын 60 жилийн ойн медалиар шагнагдлаа. Мөн энэ өдрийн гол үйл явдал нь Баянгол сумаас төрсөн Монгол улсын хөдөлмөрийн баатар Чойжамцын Баяраагийн дурсгалын хөшөөний нээлтийг хийж, алдар нэр, дүрийг нь үүрд мөнхлөн үлдээж хүндэтгэл үзүүллээ. Сумын соёлын төвөөс Ойд зориулсан “Атар нутгийн дуулал” уран бүтээлийг шинээр тавьж 84 авьяастан оролцлоо.

Сумын ИТХ-ын XVI хуралдаан 2019 оны 12 дугаар сарын 19, 20-ны өдрүүдэд болж 2019 оны сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, 2020 оны сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсөв, газар зохион байгуулалтын төлөвлөгөөг тус тус баталлаа. Мөн сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтэд үнэлэлт дүгнэлт өгч ажиллалаа.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 50 дугаар тогтоолоор батлагдсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хууль зүйн үндэсний хүрээлэн, аймгийн Хууль эрх зүйн хэлтэсээс иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл, сурталчилгааны www.e-khutuch.mn портал цахим хуудсыг сурталчлах зорилгоор хүлээлгэн өгсөн иж бүрэн компьютер, принтерийг Засаг даргын тамгын газрын 1 давхарт эрх зүйн хөтөчийн булан нээж уг цахим хуудсыг иргэдэд сурталчлан ажиллаж байна. Энэхүү буланг тохижуулахад ЗДТГ-аас 1,0 сая төгрөг зарцууллаа.

Сумын Засаг даргын 2019 оны А/266 тоот Мал тэжээвэр амьтад, хашаа, худгийн ээлжит тооллого явуулах тухай захирамж гарч 2019 оны жилийн эцсийн мал тэжээвэр, амьтан, хашаа, худаг усны тооллого явуулах сумын ажлын хэсэг байгуулагдан 2019.12.07-2016.12.11 хооронд 14 чиглэлд 45 хүний бүрэлдэхүүнтэй 8 тээврийн хэрэгсэл дайчлан мал тооллогын ажлыг зохион байгуулж дууслаа. Тооллогоор 449 малчин, 384 мал бүхий өрхийн 158157 толгой мал тоологдож өнгөрсөн онтой харьцуулахад 19360 толгой малаас өссөн үзүүлэлттэй байна. Үүнд адуу 10074, үхэр 17315, хонь 78434, ямаа 52334 тоологдлоо.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2019 оны 1/900 тоот Хэлэлцүүлэг зохион байгуулж, санал ирүүлэх тухай албан бичгийн дагуу Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн “ж”-д зааснаар аймгийн нутаг дэвсгэр дэх худалдаа үйлчилгээний газрын үйл ажиллагаа эрхлэх цагийн хуваарийг баталж мөрдүүлэхтэй холбогдуулан тус сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 15 аж ахуйн нэгж байгууллага, 50 иргэний дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, санал асуулга авч ажиллалаа. Санал асуулгыг авч нэгтгэхэд: цагийн хуваарийг тогтоосон хугацаагаар нь байлгах нь зүйтэй гэж 49 иргэн буюу 73,4 хувь нь үзсэн байна.

Тус сумын нутаг дэвсгэрт Согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагууд долоо хоногийн аль гараг бүр согтууруулах ундаагаар худалдаа үйлчилгээ эрхлэхгүй байх гэсэн асуултад санал асуулгад оролцсон иргэдээс 46 иргэн буюу 70,8 хувь нь Даваа гарагт, 19 иргэн буюу 29,2 хувь нь Ням гарагт архи согтууруулах ундаа худалдаалахгүй өдөр байх саналыг өгч байна.

Сумын эрүүл мэндийн төв Амбулаториор нийт 761 иргэнийг үзлэгт хамруулан, дээд шатлалын эмнэлэгт 41 иргэнийг онош тодруулахаар илгээсэн. Хүлээн авах хэсгээр 326 иргэнд өдрийн эмчилгээг эмчийн заалтаар хийж үйлчилсэн. Стационарт 54 хүнийг хэвтүүлэн 820,0 мян/төгрөгийн эм тариа, ороох боох материал зарцуулан, эмчилсэн. Түргэн тусламжийн нийт 166 дуудлага хүлээн авснаас алсын 31, осол гэмтлийн 2 дуудлаганд явж үйлчилсэн. Эх хүүхдийн эрүүл мэнд хоол тэжээл хөтөлбөрийн хүрээнд 0-5 насны 141 хүүхдийг жинлэн, товлолын дагуух дархлаажуулалтанд 100 % хамруулсан.

Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйл, 51 дүгээр зүйлийн 51.2, Эрүүл мэндийн сайдын 2017 оны “Томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх, хянах ажлыг эрчимжүүлэх тухай” 04 тоот албан даалгавар, 2017 оны А/41 тоот тушаал “Гэрээр сувилахуйн тусалмж үйлчилгээ үзүүлэх журам”, аймгийн Эрүүл мэндийн газрын даргын 2019 оны А/87 тоот тушаалын хэрэгжилтийн хүрээнд Эрүүл мэндийн төвийн даргын 2019 оны А/72 тоот тушаалыг гарган, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, эмч, мэргэжилтнүүд уртасгасан цагаар ажиллаж, амбулаторийн үзлэгийг гэрийн эргэлтэнд шилжүүлэн, 0-5 насны хүүхэд, өндөр настан, архаг хууч өвчтэй иргэдэд гэрээр тусламж үйлчилгээ үзүүлж, мэдээлэл сургалт сурталчилгааны гарын авлага тараан, сэрэмжлүүлж дараах ажлуудыг зохион байгуулж байна.

ЭМЯ-аас зарласан “Тэмбүүг устгая” аян хүрээнд “Тэмбүүгүй сум” болох уриан дор 76 иргэнийг ДОХ, тэмбүүгийн түргэвчилсэн сорилд хамруулахад 5 өвчлөл илэрснийг эмчилгээнд хамруулсан. Хөх умайн хавдар эрт илрүүлэг үзлэг

шинжилгээнд 287 эмэгтэй хамрагдахаас 191 эмэгтэй хамрагдаж 68%-тай байна. Сумын нөхөн үржихүйн насны 1413 эмэгтэйгээс ЖСА хэрэглэлт 32,5%-тай байна.

Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, сангийн сайдын 2010 оны 24/34 тоот хамтарсан тушаалын дагуу 2019 онд улаан буудай тариалан үндэсний үйлдвэрт тушаасан 8 аж ахуй нэгж, 3 иргэний 2711 тн будаан урамшууллын материалыг бүрдүүлж холбогдох газарт хүргүүлсэн. Мөн Монгол Улсын Засгийн газрын 202, 338 дугаар тогтоолын дагуу Улсын аварга тариаланч хамт олон-1, Улсын аварга малчин өрх- 1, Алтан төлийн эзэн- 3, аймгийн аварга тариаланч-1, аймгийн аварга малчин-2 иргэний материалыг гаргаж аймгийн ХХААГ-т хүргүүлэв.

Орхонтуул сум:

Сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд “Архи үгүй амьдрал аз жаргалтай” аяныг сумын Засаг даргын 2019.08.28-ны өдрийн А101 тоот захирамжаар зохион байгуулж байна. Аяны хүрээнд суманд үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зөвшөөрөлтэй цэгүүдэд хяналт шалгалт хийх болон мэдээлэл сурталчилгааны ажлууд зохион байгуулагдаж байна. Сумын ИТХ-ийн ээлжит 20-р хуралдаанаар 2019 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийг дүгнүүлж 2020 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэлэлцүүлэн батлуулж ажилласан байна. Мөн сумын Иргэдийн төлөөлөгчдийн 2019 оны 11-р сарын 29-ний өдрийн хуралдаанаар 2020 онд Сум хөгжүүлэх сангийн Тэргүүлэх чиглэл, хүү, төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, Төслийн гүйцэтгэлд хяналт тавих ажлын хэсгүүдийг шинэчлэн байгууллаа.

“Даатгуулагч танд урьдчилан зөвлөө- тусалъя” аяны хүрээнд 2019-2020 онд тэтгэвэр тогтоолгох иргэдийн судалгааг гарган 3 даатгуулагчдад зөвлөмжийн хуудас өгч зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаа.

Сумын Хөдөлмөр эрхлэлтийн албанд ажил хайгчаар бүртгүүлсэн 4иргэн ажилд зуучлагдсан 3 иргэнийг бүртгэл мэдээллийн санд баталгаажууллаа. Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Рашаант тосгоны Хонхор хороололд Хүүхдийн тоглоомын талбай барих, Баянцогт 2-р багийн Дэл хороололд Хүүхдийн тоглоомын талбай барих, 1 болон 2-р багийн төвийн Гэрэлтүүлэгийн засварын ажлын гүйцэтгэлийг хүлээн авлаа.

Атар газар эзэмшсэний түүхт 60 жилийн ойг угтан зохион байгуулах арга хэмжээний хүрээнд “Атар газар арвай буудай” уриатай хүмүүнлэгийн аяны ажил арга хэмжээг зохион байгуулан ажиллаж нийт 860200 төгрөгийн хандив цугларсан бөгөөд уг хандивыг атрын анхын шан таталцаж байсан Баянцогт 2-р багийн Иргэн С.Юухуар Рашаант 1-р багийн иргэн Л.Баасан нарт Атрын 60 жилийн ойн арга хэмжээний үеэр гардуулан өглөө.

Монгол Улсад Газар тариаланг шинжлэх ухааны үндэслэлтэй хөгжүүлсэний түүхт 60 жилийн ойн баярын арга хэмжээг сумандаа 2019 оны 12-р сарын 20-ны өдөр зохион байгуулан нийт 212 хүнийг хүлээн авч 177 тариаланч, тухайн үед ажиллаж байсан ажилчдыг шагнаж урамшууллаа. Сумын шинэ жилийн баярын арга хэмжээг 2019.12.30-ны өдөр зохион байгуулж Сумын шилдгүүдийг тодруулан шагнаж урамшууллаа.

2019 оны 12-р сарын 07-ноос 17-ны өдрүүдэд Улсын Мал тооллогын ажил зохион байгуулагдаж нийт 3 багийн 744 өрхийн малын тоог гарган баталгаажууллаа.

Сумын хэмжээнд нийт 212560 толгой мал тоологдсон байна. Үүнээс:

- Шар-Ус 1-р баг-83480
- Баянцогт 2-р баг-71417
- Хонгор-Овоо 3-р баг-57663 байна.

Аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газар руу “Улсын аварга малчин”-д малчин Ц.Нямаа, П.Санж, Аймгийн аварга тариаланч хамт олонд “Цайлган” ХХК, Аймгийн аварга тариаланчаар Т.Ням-Од, “Агрошим” ХХК-ний бригадын дарга И.Отгонсүрэн нарын материалыг бүрдүүлэн хүргүүлээ.

Хушаат сум:

Сумын "Атар 60-Ургацын баяр" арга хэмжээг зохион байгууллаа. Арга хэмжээний үеэр газар тариалангийн салбарт олон жил үр бүтээлтэй ажилласан тус сумын харъяат зарим иргэдэд төрийн дээд шагнал гардуулсан. Үүнд: "Алтан гадас одон"-гоор ахмад тариаланч, анхны атарчин Хишигтогтохын Шуурай, "Энх Хушаат" ХХК-ий жолооч Доржийн Пүрэвдорж, "Хөдөлмөрийн хүндэт медаль"-иар Ядамжавын Мөнхбаяр, Жаргалтайн Эрдэнэ-очир, "Атарчдын алдар" медалиар анхны атарчин ахмад тариаланч Б.Нямаа, Д.Пүрвээ, А.Төмөрбаатар, Х.Доржбазар, Г.Наранцэцэг, "Элит үр" ХХК-ий бригадын дарга Ц.Бат-очир, "Нью кроп" ХХК-ий агрономич Б.Эрдэнэбаатар "Шандас өгөөж" ХХК-ий захирал Д.Энхсайхан, "Элит үр" ХХК-ий тракторч Т.Батбаатар, "Хушаат агро" ХХК-ий захирал М.Энхбаяр, "Өгөөж мандал уул" ХХК-ий тракторч Н.Жаргалбат, "Голын өндөр" ХХК-ий тариаланч Ч.Пүрэвсүрэн, "Монгол Ангус" ХХК-ий менежер Б.Эрдэнэбаатар, БНЭХ ХХК-ий захирал Х.Мижиддорж, "Момо агро" ХХК-ий тракторч Д.Эрдэнэбаатар, "Энх Хушаат ХХК-ий бригадын дарга О.Баярдалай, "Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн тэргүүний ажилтан" цол тэмдгээр "Хайрхан оргил уул" ХХК-ий тогооч Н.Мөнхтунгалаг, "Энх Хушаат ХХК-ий бригадын дарга О.Баярдалай, тариаланч П.Нэргүй, Сэлэнгэ аймгийн "Хүндэт тэмдэг"-ээр ахмад тариаланч Л.Дондог, А.Төмөрбаатар нар шагнагдсан. Мөн Атарын 60 жилийн ойн медалиар 73 иргэнийг шагнаж урамшуулсан.

Ойн арга хэмжээний хүрээнд "Гэрэл зураг түүх өгүүлнэ" зурагт самбарыг гаргаж, "Хушаатад үйлдвэрлэв" үзэсгэлэн худалдааг 2 өдөр зохион байгуулж, нийт 12 үйлдвэрлэл эрхлэгч оролцож хүнсний ногоо, даршилсан ногоо, сүү, цагаан идээ, дармал болон хатаасан бүтээгдэхүүн, оёмол болон шигтгэмэл бүтээгдхүүнийг борлуулж үйлчиллээ.

Мөн ойд зориулан Атарын 1,2-р аянд ажиллаж хөдөлмөрлөж явсан Н.Нямаа, Д.Пүрвээ, Г.Очир, Л.Дондог, М.Эрхэмбаяр, Д.Загдаахүү, Н.Даш, Д.Рэнцэнханд, Р.Шагдар, С.Лхагвасүрэн, Х.Намсрайжав, Х.Шуурай, П.Тогоо, Ө.Гаадай, Д.Гомбо, Л.Дондог, Отгонжаргал, Долгор, С.Лхагвасүрэн, Д.Оюун, Б.Булдууч, А.Төмөрбаатар нарын дурсамж яриаг гэрэл зургийн хамт сумын "Нээлттэй Хушаат" цахим хуудас болон Fb хуудсанд нийтэлж олны хүртээл болгож ажиллалаа.

Сумын иргэд, залуусын дунд чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, илүүдэл жингээ хаях, хөдөлгөөний хомсдлоос урьдчилан сэргийлэх, бүжгийн эвсэлтэй болгох зорилгоор "Би жингээ хаямаар байна" зумба бүжгийн сургалтыг 7 хоног бүрийн мягмар, лхагва гараг бүр тогтмол хичээллүүлж нийт 20 иргэн хамрагдсан.

Сумын 1-р цэцэрлэгийн хүүхэд өдрийн төлөвлөгөө 12-р сарын 01-31-ний байдлаар хамран сургалт нийт 2200 хүүхэд хүлээн авахаас 1339 хүүхэд авч ирц 61 хувьтай байна. Ханиад томуу ихтэй учраас хүүхдүүдийн ирц буурч өвчлөл ихсэж байна. Үүнтэй холбогдуулан тогооч, бүлгийн багш нар илчлэг тэжээлтэй хоол, витаминжуулалтыг үргэлж хийж анхаарч ажиллаж байна.

Эрүүл мэндийн төвд ор хоног 65, эмнэлэгт хэвтсэн 10, эмнэлгээс гарсан 11, үзлэгийн тоо бүгд 150, Амбулатори 120, урьдчилан сэргийлэх 30, идэвхитэй хяналт 12, хяналтанд байгаа жирэмсэн 11, шинээр хяналтанд орсон 2, 0-5 насны жинэлсэн хүүхдийн тоо 130, Д-амин дэм уусан хүүхэд 10, А-амин дэм уусан хүүхэд 20, Түргэн тусламжийн дуудлага 30, Үүнээс алсын дуудлага 6, артерийн гипертензи эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан хүний тоо 10, чихрийн шижин хэв шинж 2 эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан хүний тоо 10, урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан хүүхдийн тоо 17, Шинжилгээнд хамрагдсан хүний тоо 21, элэгний эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан 10 иргэн байна.

Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах үүднээс 94м³ түлшний модны эрхийн бичиг бичигдэн 129.000 төгрөгийн орлого, ТТАМ-ын орлого 150.000 төгрөг, агнуур ашигласны төлбөр 1500.000 төгрөг, ойн нөөц ашигласны төлбөр 7500.000 төгрөгийг Ундруул, Соёолж ХХК-иудаас тус тус оруулсан байна. Хяналт шалгалтаар хөдөөгийн чиглэлд 1 удаа явсан байна.

2019 оны жилийн эцсийн мал тооллогоор нийт 88504 толгой мал, үүнээс адуу 3579, үхэр 12919, хонь 39769, ямаа 32237 толгой тоологдлоо.

Цагааннуур сум:

Атрын 60 жилийн ойг угтан ЕБС-ийн бага, дунд, ахлах ангийн сурагчдын дунд наамал, гар зураг, эсээ бичлэгийн уралдаан зарлаж, сумын төвийн зам дагуу баярын мэндчилгээт самбаруудыг байрлуулаад байна.

Төрийн албан хаагчдын “Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж” нээлттэй мэдээллийг даваа гариг бүр зохион байгуулж иргэд, иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчдөд танилцуулж хэвшээд байна.

Атрын 60 жилийн ойд зориулсан баатар, гавъяат, аварга, атрын түүхэн баатруудтай хийх уулзалтыг 2019 оны 12 сарын 09-нд амжилттай зохион байгууллаа. Энэ үеэр ахмад болон шинэ үеийн тариаланчид өөрсдийн дурсамжийг хуваалцсан бол сурагчид маань газар тариалангийн салбарт залуу халуун насаа зориулсан эмээ, өвөө, аав, ээж, ах, эгч нартаа зориулан бичсэн захидалаа уншиж сонордуулж, бүтээлч сурагчид маань өөрсдийн гараар хийсэн бүтээлүүдээ гардуулан өглөө.

2019 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Атрын 60 жилийн ойг тохиолдуулан жижиг дунд өрхийн үйлдвэрлэгчдийн “Үзэсгэлэн худалдаа зохион байгуулагдаж” нийт 18 иргэд оролцсон. Шилдэг эко бүтээгдэхүүнээр Л.Тунгалаг, Д.Цогзолмаа, Ц.Ичинхорлоо, нар амжилттай оролцож өргөмжөл мөнгөн шагналаар шагнагдлаа. Д.Наранцэцэг нь Атрын 60 жил гэсэн логоог оролцуулан цөцгийн тосоор бялуу хийж шилдэг бүтээгдэхүүнээр шалгарсан.

Атрын 60 жилийн ойд зориулсан сумын волейболын аварга шалгаруулах тэмцээн, “Атарчид дуулж байна” дууны тэмцээн, “Атрын түүх- Атрын амжилт” хүндэтгэлийн уулзалт, урлагийн тоглолт, Баярын хурал, шагнал гардуулах ёслол зэрэг олон сайхан үйл ажиллагаа зохион байгууллаа.

Мөн жил бүр зохион явуулдаг мал, тэжээвэр амьтад хашаа худгийн тооллого 12 сарын 07-ны өдрөөс 17-ны хооронд зохион байгуулахаар захирамж гарч тооллогын ажлын хэсгээс баг тус бүрийн ажлын хэсгийн тоологч нарт сургалт хийж, тооллогыг амжилттай зохион байгууллаа.

Суманд хүнсний аюулгүй байдлыг хангуулах үүднээс “Шинэ жилийн баяр”-ын үеэр хоолны хордлого гарахаас сэргийлэх, хүнсний бараа, түүхий эд бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авч, холбогдох хууль, дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хангуулах, шалгалтын явцад илэрсэн зөрчлийн шаллтгааныг тогтоож, дутагдлыг арилгуулж, эрсдэлээс сэргийлэх, иргэдэд зөвлөмж, зөвлөгөө өгөх, сэрэмжлүүлэг хүргэх зорилгоор хяналт шалгалт хийлээ.

Шалгалтыг ХЧСХМэргэжилтэн Г.Сумъяасүрэн, татварын байцаагч Т.Энхбат, байгаль орчны хяналтын улсын байцаагч И.Наранбаатар, Тархвар зүйч М.Баярмагнай, сумын хэсгийн төлөөлөгч, малын эмч Б.Эрдэнэчимэг, хэрэглэгчийн эрх ашиг хамгаалах гишүүн нарын бүрэлдэхүүнтэйгээр 2019 оны 12 сарын 25-ны өдрөөс 2019 оны 12 дугаар сарын 26-ны хүртэл хийж гүйцэтгэв.

Шалгалтаар нийтийг хамарсан баяр ёслолын үеэр гарч буй өргөтгөсөн худалдаа, явуулын худалдаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, худалдаалагдаж буй бараа бүтээгдэхүүний шошгололтын байдал, тухайн барааны чанар илт муудсан эсэх, хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодлын бүрэн байдал, шалгалтын явцад хаяг шошгын зөрчилтэй, хадгалах, худалдаалах нөхцөл зөрчигдсөн, сэжигтэй бүтээгдэхүүнээс дээж авч шинжлүүлэх, худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуй нэгжийн ажиллагсад эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээндээ хамрагдсан эсэх, худалдаа, үйлчилгээний газруудын тоног төхөөрөмжийг хуваарийн дагуу бүрэн угааж, халдваргүйжүүлсэн байдал, импортын хүнсний түүхий эд бүтээгдэхүүний шошгололтонд тандалт судалгаа хийж, хяналт шалгалт зохион байгуулж ажиллаа.

Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтанд суманд худалдаа үйлчилгээ эрхэлдэг хүнс барааны дэлгүүр 3, минимаркет 4, цайны газар 2 зэрэг газрууд хамрагдав.

Шалгалтанд хамрагдсан худалдааны газрууд нь ажлын байрандаа өргөтгөл, засварын ажил хийж, баталгаат жин хэмжүүртэй, зориулалтын хөргөх, хөлдөөх төхөөрөмжүүдтэй, лангуу тавиур нь шаардлага хангахуйц, мэргэжлийн худалдагчтай байлаа.

НӨАТ-ын баримтыг тогтмол өгдөг болох тал дээр татварын байцаагч зөвлөмж зөвлөгөө өгч ажиллаа.

Сумын МАА-н хэтийн төлөвийн талаар судалгаануудыг гаргаж, цаашид авах арга хэмжээний талаар “Ногоон алт” төсөлтэй хамтран ажиллаж, 2019 оны байдлаар 11 БАХ байгуулагдан, 9 БАХ багийн ИНХ-аар дэмжигдээд байна. Цаашид малчид, мал бүхий иргэд, аж ахуйн нэгжид үзүүлэх хөнгөлөлт, дэмжлэг, үйлчилгээний шалгуур үзүүлэлтэнд БАХ-ийн үйл ажиллагааг үндсэн шалгуур болгох бодлого баримталж байна.

2019-2020 онд нийт 389 хот айлд 523 өрхийн 180 000 толгой мал өвөлжих урьдчилсан мэдээлэл байгаа бөгөөд нийт 9530 тонн өвс, 15000 тонн дарш, 480 тонн давс хужир бэлтгэсэн байна.

2019 оны жилийн эцсийн байдлаар талбайд мод бэлтгэх талбай тусгаарлалтын ажлуудыг суманд УБТЗ-ын МБҮйлдвэр үйлдвэрлэл, арчилгаа, цэвэрлэгээний огтлолтоор 236 га талбайд мод бэлтгэх талбай тусгаарлалтын ажлуудыг шинэс мод бэлтгэлд 4 хэсэг талбайгаас хэрэглээ 1222.23м3, түлээ 174,47м3, нарс мод бэлтгэлд 4 хэсэг талбайгаас хэрэглээ 649.74м3, түлээ 262.12м3 бэлтгэн тээвэрлэлт бүрэн хийж талбайг хүлээлгэн өгсөн.

Жавхлант сум:

Тайлант сард сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал хуралдаж, 2019 оны төсвийн гүйцэтгэл, 2020 оны төсвийн төслийг хэлэлцэн баталлаа.

Атар газар эзэмшсэний түүхт 60 жилийн ой, Алтан намар ургацын баярыг хамтатган тэмдэглэн өнгөрүүлээ. Арга хэмжээний үеэр үе үеийн алдартан гавъяаны эзэд тариаланчид, ногоочидоо шагнаж урамшууллаа. Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одонгоор З.Сүхээ, Л.Төмөрбаатар, алтан гадас одонгоор Д.Насанбат, хөдөлмөрийн хүндэд медалиар И.Бат-Очир, Б.Санжмятав, Ц.Одбүрэн, С.Эрдэнэбат мөн атарчдын алдар медалиар 22, хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрийн тэргүүний ажилтан 25, худалдаа үйлдвэрийн тэргүүний ажилтан 4, хүнс хөдөө аж ахуйн хүндэт жуух 6, улс, аймгийн атар 60 ойн медаль 110, аймгийн Засаг даргын хүндэт жуух бичиг 5, аймгийн ИТХ-ийн өргөмжлөл 1, сумын ИТХ-ийн өргөмжлөл 3, сумын Засаг даргын хүндэт жуух 4, сумын Засаг даргын талархал 4 тус тус шагнагдлаа. Энэ жилийн ургацын аваргуудаа шалгаруулж, өргөмжлөл мөнгөн шагналаар мөн шагнасан. Үүнд: Нэгж га талбайгаас хамгийн өндөр ургац хураан авсан аж ахуйн нэгжээр “Бадрал-трейд” ХХК, шилдэг механикжуулагчаар П.Эрдэнэбат, шилдэг ногоочноор Ж.Отгонбаатар, нийгмийн хариуцлага, техник технологийн шинэчлэл аж ахуйн нэгжээр “Өгөөмөр хантайж” ХХК, Байгууллага сурталчилах сарын аяны хүрээнд бусдыгаа манлайлан түрүүлсэн аж ахуйн нэгж байгууллагаар “Мон-жим”, “Өгөөмөр хантайж”, “Тариатын буудай” ХХК, Соёлын төвийн хамт олон шалгарч өргөмжлөл 500000 төгрөгөөр шагнагдлаа.

Сумын засаг даргын А/106 тоот захирамжаар жилийн эцсийн мал тооллого 8 хэсэгт явагдаж нийт сумын хэмжээнд 426 өрх тооллогод хамрагдаж дууссан.

12 дугаар сард төрсний бүртгэл -2, шилжилт хөдөлгөөн-5, иргэний үнэмлэх олголт-5, гэрлэлтийн бүртгэл-1, шинээр иргэний үнэмлэх -1, иргэний үнэмлэхний захиалга 1, овог нэр өөрчлөлтийн бүртгэл-0, үрчлэлт-0 нийт 15 иргэнд бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өдөрлөгийг зохион байгуулж "Кара-Оке" дуунытэмцээн, бүжгийн тэмцээн, сагсан бөмбөгийн тэмцээнийг ХБИ-ийн холбоотой хамтран зохион байгуулснаас гадна мөн иргэдийн шинэ жилийн баярын арга

хэмжээг төр төсвийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж нийт 25 иргэн оролцон энэ оны амжилт бүтээлээ дүгнэлээ.

Тайлант сард сумын эрүүл мэндийн төвд 472 үзлэг хийгдэж, иргэдэд хөнгөлөлттэй жороор 18 иргэнд 199000 төгрөгийн өртөг бүхий хөнгөлөлттэй эмээр үйлчилж зөвлөгөө өгч ажилласан. Дархлаажуулалтанд товллын дагуу хүүхдийг хамруулан эхэд нь ДДУХ-ийн талаар зөвлөгөө өгч ажиллалаа. Хөдөөгийн эргэлтээр 0-5 насны 76 хүүхдэд жинлэлт хийж, жирэмсэний шинэ болон давтан хяналтанд байгаа 9 эхийг үзэж зөвлөгөө өгч шинээр хяналтанд авсан 2 эхийг жирэмсэний хяналтанд нарийн мэргэжлийн эмч нарийн үзлэг шинжилгээнд хамруулахаар явууллаа.

Сумын хэмжээнд томуу томуу төст өвчин гаралт сүүлийн 7 хоногийн байдлаар нийт 61 амбулаторын үзлэгийн хийгдсэнээс 20%, түргэн тусламжийн дуудлагын нийт 26 дуудлага ирсэнээс 81%-ийн эзэлж томуу томуу төст өвчин эзэлж байгаа учир амбулаторын үзлэгийг гэрийн эргэлтэд шилжүүлэн гэрийн эргэлтийг түлхүү хийх ажлыг зохион байгуулаад байна.

Монгол улсын хөдөлмөрийн баатар, Улсын их хурлийн гишүүн, Эрдэнэт үйлдвэрийн ерөнхий захирал агсан Ш.Отгонбилэгийн нэрэмжит өсвөр үеийн аварга шалгаруулах чөлөөт бөхийн 18 дахь удаагийн олон хот, улсын нээлттэй тэмцээнд Ц.Мөнхцэцэг багштай ба ангийн сурагч Г.Чинзориг 26 кг-ийн жинд барилдаж мөнгөн медаль хүртсэн амжилт гаргалаа.

Сурагчдын авьяас чадварыг нээн илрүүлэх, анги нийтээрээ оролцох, гоо зүйн хүмүүжлийн төлөвшлийг олгож, идэвхиоролцоог нэмэгдүүлэх, хамтач нөхөрсөг, тусч зан чанарыг төлөвшүүлэх зорилгоор ЕБС-ийн 1-12-р ангийн сурагчдын **“Урлагийн бага наадам-2019”**-ыг амжилттай зохион байгууллаа.

Сумын Моностой 2-р багийн Цагаан даваа гэх газраас ойн цэвэрлэгээний журмаар нийт 15 иргэн ойгоос түлээний мод болох унианги гишүү мөчир, модыг бэлтгэх эрхийн бичгийг авч бэлтгэсэн байна. Ойгоос түлээний мод бэлгэж ашигласны төлбөр болох 123120 төгрөгийн орлогыг орон нутгийн төрийн санд оруулж ажилласан.

Сант сум

Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн 2019 оны жилийн эцсийн тооллогын ажлыг зохион явуулах тухай сумын Засаг даргын 12 дугаар сарын 03-ны өдрийн А/138 тоот захирамжаар мал тооллогын комисс 35 хүний бүрэлдэхүүнтэй томилогдон сумын нутаг дэвсгэрийн 9 чиглэлд тооллогын ажлыг хийж гүйцэтгэлээ. 2019 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр тэмээ 2, адуу 5000, үхэр 11107, хонь 41301, ямаа 28071, бүгд 85481 толгой мал тоологдсон байна. Тооллогын ажилд 832,6 мянган төгрөгийн зардал зарцуулагдсан байна. Мөн тэжээвэр амьтад 54 гахай, 336 тахиа, галуу 4, цацагт хяруул 5,321 хашаа, 61 худаг тоологдсон дүнтэй байна. Хяналтын тоо 2 чиглэлд хийгдэж 18 өрхийн 5108 толгой мал хамрагдсан байна.

Монгол Улсад атар газар эзэмшиж, газар тариаланг бие даасан салбар болгон хөгжүүлсний 60 жилийн ойн баярын арга хэмжээг суманд 12 дугаар сарын 13,14-ний өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлээ. Арга хэмжээний хүрээнд баярын хурал, хүндэтгэлийн тоглолт, үндэсний бөхийн барилдаан, үдшийн цэнгүүнийг зохион байгууллаа. Энэ үеэр “Атар 60” хүндэтгэлийн самбар, “Атарчдын бахархал” гэрэл зургийн үзэсгэлэн гаргалаа. Ойн баяраар сумын газар тариалангийн салбарт хөдөлмөрлөж байсан, ажиллаж байгаа үе үеийн атарчид, тариаланчдын амжилтыг алдаршуулж Төрийн дээд одон медалиар 24 хүн, Тэргүүний ажилтан цол тэмдгээр 14 хүн, аймгийн ИТХ-ын хүндэт тэмдэг, өргөмжлөлөөр 3 хүн, Яам, аймаг, сумын Засаг даргын жуух бичиг, хүндэт өргөмжлөлөөр 25 хүн, улсын атрын 60 жилийн ойн медалиар 32 хүн, аймгийн атрын 60 жилийн медалиар 70 хүнийг шагнаж урамшуулсан.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2019 оны 01/742 албан тоотын дагуу шинэ жилийн баяр болж байгаатай холбогдуулан сумын Ерөнхий боловсролын

сургууль, 1-р цэцэрлэг, Соёлын төвийн байранд хүлээн авалт, цайллага зэрэг согтууруулах ундаа, ширээ засалттай арга хэмжээ зохион байгуулахыг хориглосон сумын Засаг даргын А/148 тоот захирамж гарч хяналт тавьж ажиллаж байна.

Тайлант сард хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй 18 иргэн байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн жижиг зээлд хамрагдах 2 иргэний бүртгэлийн маягтыг хийж аймгийн ХХҮГ-т хүргүүлж Төрийн банкаар 2 иргэнд 10 сая төгрөгийн зээлийг 24 сарын хугацаатай олголоо.

Сайхан суманд зохион байгуулагдсан Орхон бүсийн “Ногоон гэрэл-Цагаан шугам” тэмцээнд сумын ЕБС-ийн 4-5-р ангийн сурагчид амжилттай оролцож “Шонхор” баг тусгай байранд шалгарлаа. Мөн аймгийн ЕБС-ийн сурагчдын дунд зохиогддог Сүхбаатар сумын нэрэмжит “Сэтгэмж-2019” уран зургийн XIV уралдаанд сумаас 13 суралцагч оролцож, 3 сурагч медальт байр шалгарсан.

Аймгийн төвд зохион байгуулагдсан "САМБО-2020" аймгийн өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээнд 34 тамирчид оролцож 5 алт, 6 мөнгө, 10 хүрэл медаль хүртсэн амжилтыг үзүүллээ.

Сүхбаатар сум:

Аймгийн Засаг даргын 2017 оны А/458 тоот захирамжаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, хугацаатай тайлан мэдээнд хяналт шинжилгээ үнэлгээ хийх журам”-ын дагуу 2019 оны жилийн эцсийн тайлан мэдээг Засаг даргын зөвлөл танилцуулан хугацаанд нь гарган хүргүүлж ажиллалаа.

Атар-60 жилийн ойн баярыг тохиолдуулан газар тариалангийн салбарт ажиллаж байсан иргэдийн судалгааг гаргаж төрийн одон медаль 14 иргэн, аймгийн “Атар-60” медалиар 40 иргэн шагнагдлаа.

Жимс жимсгэнийн хураалтын мэдээг шивж программд орууллаа. Ургац хураалт сумын хэмжээнд 30770тн үүнээс чацаргана 18300, үхрийн нүд 10248, алим 38, бөөрөлзгөнө 245, гүзээлзгэнэ 120, бусад 1819 тус тус хураан авлаа.

Сумын засаг даргын захирамжаар жилийн эцсийн мал тооллогын ажлын хэсэг байгуулагдаж сумын хэмжээнд нийт нийт 330 өрхийн 23277 мал үүнээс: адуу-2867, үхэр-5524, хонь-6937, ямаа-7949, Тэжээвэр амьтан гахай -242, зөгий 719 бүл, шувуу-1539, эрлийз мал-3810 тус тус тоологдлоо.

Халдварт болон халдварт бус үзлэгийн эрт илрүүлэгийг Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газар, “Номтхан” өрхийн эрүүл мэндийн төв хамтран 2019 оны 12 дугаар сарын 12-ноос 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа.

Урьдчилсан сэргийлэх үзлэгт нийт 714 иргэн хамрагдсан байна. Эрсдэлт бүлгийн 0-16 насны хүүхдүүдэд БЦЖ-ийн сорил тавьж ажиллалаа.

Тэмбүү илрүүлэх шинжилгээнд эрсдэлт бүлгийн 16-49 насны нийт 200 залуучуудаас шинжилгээ авч, шинжилгээ эерэг гарсан 8 иргэнийг эмчилгээнд оруулан, хяналтандаа авч ажиллаж байна. Халдварт болон халдварт бус үзлэгийн эрт илрүүлэгийг зохион байгуулахад шаардлагатай байсан зардал 400.000 төгрөгийг сумын Засаг дарга шийдвэрлэж өглөө.

“Атар газар эзэмшсэний 60 жилийн ой”-г тохиолдуулан Ахмадуудын дунд зохион байгуулагдсан Хийн дасгал, Шагайн наадгайн аймгийн аварга шалгаруулах тэмцээнд тус сумын ахмадууд авьяас чадвар, цэц мэргэнээ сорин амжилттай оролцлоо. Багийн нийлбэр дүнгээр Сүхбаатар сум ТЭРГҮҮН байранд шалгарлаа.

Сүхбаатар сумын Ахмадын “Шинэ жил”-ийн баярын арга хэмжээг 2019 оны 12 дугаар сарын 21-ний өдөр Спортын ордонд зохион байгуулж, 8 багийн 200 гаруй ахмад настан оролцлоо. Нээлтийн үйл ажиллагаанд Засаг дарга Т.Гантулга, аймгийн Ахмадын хорооны удирдах зөвлөлийн гишүүн Л.Цэндсүрэн, сумын Ахмадын хорооны дарга Д.Даваасамбуу нар оролцлоо.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдрийг угтан 2019 оны 11 дүгээр сарын 27-28-ны өдрүүдэд аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан “Бид чадна” урлаг, спортын өдөрлөгт сумын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг зохион

байгуулан амжилттай оролцлоо. “Бид чадна” урлаг, спортын өдөрлөгт тус сумын 30 гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэд оролцож, авхаалж самбаа, оюун ухаан, авъяасаараа бусад сумдын хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй 2 өдөр өрсөлдлөө.

“Бид чадна” урлаг, спортын тэмцээний нийлбэр дүнгээр Сүхбаатар сумын хөгжлийн бэрхшээлтэй иргэд ТЭРГҮҮН байранд шалгарч, Шилжин явах цом, Алтан медаль, Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдлаа.

Сүхбаатар сумын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн “Шинэ жил”-ийн баярын арга хэмжээг 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Төмөр замын клубт зохион байгуулж, 8 багийн 150 гаруй иргэд оролцлоо.

Түшиг сум:

Монгол Улсад атар газар эзэмшиж, газар тариалангийн салбар бие даан хөгжсөний түүхт 60 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсгийг Засаг даргын орлогчоор ахлуулан байгуулж нийт 18 ажил арга хэмжээг төлөвлөж, сумын хэмжээнд 12 дугаар сарын 12-ны өдөр тэмдэглэн өнгөрүүллээ. Атар газар эзэмшиж, газар тариалангийн салбар бие даан хөгжүүлсэний 60 жилийн ойгоор тус сумаас “Гавъяат агрономич”-оор 1 иргэн, “Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон”-оор 6 иргэн, “Алтан гадас одон”-оор 8 иргэн, “Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар 11 иргэн, “Хөдөө аж ахуйн тэргүүний ажилтан”-аар 7 иргэн, “Атарчдын алдар” медалиар 20 иргэн, “Улсын атрын 60 жилийн ойн медаль”-иар 30 иргэн, аймгийн “Атрын 60 жилийн ойн медаль”-иар 70 иргэн нийт 150 гаруй иргэн төрийн дээд одон медаль, салбарын шагналаар шагнагдлаа.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 101 тоот тогтоолоор жил бүрийн 11 дүгээр сарын 14-ний өдрийг “Түшиг сумын бахархалын өдөр” байхаар тогтлоо.

2019 оны хүн ам, мал тэжээвэр амьтаны тооллогыг амжилттай зохион байгуулж ажиллалаа.Түшиг сумын нийт хүн амын тоо 1860, 59470 тоо толгой мал тоолуулсан.

Сумын хэмжээнд шилмэл омог, цэвэр үүлдэр,эрлийз мал Үхэр Ангус 1434, халимаг монгол 5424, Хонь үзэмчин 30, баяд 78, баяд монгол 19528 нийт 26494 тоо толгой мал тоолууллаа.

2019 оны ургацаас Тариалан эрхлэх дэмжих сан, Улсын нөөцийн газар, дотоодын гурилын үйлдвэрүүдэд Монгол Улсад мөрдөгдөж буй хүнсний улаанбуудайн “ТЕШ.MNS97-2010” стандартын шаардлага хангасан хүнсий буудай нийлүүлсэн аж ахуйн нэгж, иргэдийг урамшуулалд хамруулан, одоогийн байдлаар аж ахуйн нэгж-1, иргэн -1 урамшууллын материалаа бүрдүүлээд байна.

Сумын Ерөнхий боловсролын сургууль Атарын 60 жилийн ойг угтаж “Бийрийн дугуйлан”-ийн сурагчдын бүтээлийн үзэсгэлэн гаргаж, мөн “Захиралын нэрэмжит” шалгалтыг 1-12 дугаар ангийн сурагчдын дунд зохион байгуулж байгууллагын жилийн эцсийн тайлан мэдээг цаг хугацаанд нь өгч ажилласан.Ерөнхий Боловсролын сургуулийн оны шилдэг сурагч, багш, ажилтан албан хаагчдыг тодруулж,“Оны шилдэг” сурагчаар 12 дугаар ангийн сурагч О.Номин, сурлагын аварга сурагчаар 12а ангийн сурагч Д.Энхсаран, урлагийн аварга сурагчаар 12а ангийн сурагч Т.Чингүүнчимэг, спортын аварга сурагчаар 12а ангийн сурагч Б.Билгүүдэй, “Оны аварга багш”-аар Монгол хэл уран зохиолын багш Л.Атарцэцэг, Биеийн тамирын багш Э.Батцоож, “Оны шилдэг ажилтанаар Г.Оюунгэрэл нар шалгарлаа.

ХЯНАСАН

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Ө.СУВДАА

БОЛОВСРУУЛСАН

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Ш.ЭНХМАА